

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг
Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000

MNS 6702:2017

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Улаанбаатар хот
2017 он

ӨМНӨХ ҮГ

Энэ стандартыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын, Геодези, зураг зүйн хэлтсээс боловсруулсан.

Стандарт боловсруулах судалгааг ГЗБГЗЗГ-ын Геодези, зураг зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарзаяа, Архив, мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэн Л.Мандхай нар хийж, хэлбэржүүлсэн.

Энэ стандартын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, ГХГЗЗГ-ын /хуучин нэрээр/ даргын дэргэдэх хурал болон орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын “Газрын салбарын стандартчиллын техникийн хороо /ТХ-36/-ны хуралдаанаар хэлэлцүүлэн стандарт болгон батлуулах нь зүйтэй хэмээн дэмжигдсэн болно.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ийн хамт олон болон ГЗЗХ-ийн дарга Монгол улсын зөвлөх инженер С.Энхтуяа, Монгол улсын зөвлөх инженер Ю.Чүлтэм, Монгол улсын зөвлөх инженер Г.Нарантуяа болоод бусад үнэтэй санал зөвлөгөө өгсөн геодези, зураг зүйн салбарын хамт олонд талархаж байна.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ):
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар-13343 Ш/Х – 48
Утас: 263860, 266754 Факс (976- 1) 458032
вэбсайт: www.masm.gov.mn
www.estandard.gov.mn

© СХЗГ 2017

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллагад)-д байна.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	ii
ОРШИЛ	iv
1 Хамрах хүрээ	1
2 Норматив эшлэл	1
3 Нэр томьёо, тодорхойлолт	1
4 Норматив шаардлага	1
5 Таних тэмдэгт тавих ерөнхий шаардлага	2
6 Таних тэмдгийн бичиглэлд тавих шаардлага	3
7 Таних тэмдэг	5
8 Таних тэмдгийн тайлбар, түүнд тавигдах шаардлага	35
9 Загвар сангийн ангилал, давхаргын жагсаалт	72
10 Загвар сангийн давхаргын талбарын монгол тайлбар	95
11 Загвар санд тодорхойлогдсон домэйн утгууд	96
12 Таних тэмдэгт хэрэглэх өнгөний кодлол	98
Нэмэлт мэдээлэл /Байр зүйн зурагт үгийг хураангуйлан бичих заавар/	99

ОРШИЛ

1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийг “Байр зүйн дэвсгэр зургийн томъёолсон тэмдэг - Масштаб 1:500, 1:1000, 1:2000, 1:5000” ном, Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн загвар, кодчилал /БНСУ-ын инженерүүдтэй хамтран боловсруулсан/, дэлхийн 30-аад оронд хэрэглэгддэг байр зүйн зургийн мэдээллийн сан түүний загвар зэргийг ашиглан Монгол улсад байр зүйн зураг зохиоход ашиглах стандарт болгож боловсруулав.

Уг стандартад байр зүйн болон дэвсгэр зургийн мэдээллийн санд дүрслэх элементүүдийг 26 ангилан цаашид нэмэх бололцоотой байдлаар хийв. Ангилал тус бүр өөртөө байр зүйн зурагт дүрслэгдэх элементүүдийг агуулсан бөгөөд элемент бүр өөр өөрийн хүснэгтэн мэдээлэлтэй хийгдсэн нь цаашид орон зайн мэдээллийн суурь болгон байр зүйн зургийг ашиглах боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

Таних тэмдгийг масштаб тус бүрт зураглагдах байдлаар хүснэгтээр үзүүлж, загвар сангийн бүтэц ангилал, талбарын төрөл, тэмдэгтийн утга зэргийг тодорхой үзүүлсний дээр домэйн утгыг шаардлагатай элементүүдэд тодорхойлж өгсөн. Элемент бүрт тайлбар байх бөгөөд барилга, байшин дээр нэмэлтээр тэмдэглэгдэж буй зарим элементүүд хэрэглэгчдэд байр зүйн зургаас тодорхой мэдээлэл авах болон орон зайн мэдээллийн бааз байгуулахад ашиглагдах зорилго агуулж байгаа юм. Мөн таних тэмдгийн өнгө, хэмжээг тодорхойлж, өнгийг хар, улаан, цэнхэр, ногоон, шар, ягаан буюу цэг, шугам, талбайн элементээр кодлосон нь байр зүйн болон дэвсгэр зураг нэг загвар, стандартаар хийгдэх шаардлагыг хангана.

Таних тэмдгийг Arc GIS програмд танигдах **Style file** болгож үүсгэсэн нь хэрэглэгчдэд байр зүйн болон дэвсгэр зургийн мэдээллийн сан дахь тухайн давхаргыг код тус бүрээр нь автоматаар таних тэмдэгжүүлэх бололцоог бүрдүүлж өгсөн.

Байр зүйн зураг хийж буй бүх хэрэглэгчид загвар сан, таних тэмдгийн **style file**-ийн ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-тэй холбогдож авах буюу тодруулга авч болно.

Энэ стандарт нь том масштабын байр зүйн болон дэвсгэр зураг /цаашид байр зүйн зураг гэх/зохиоход дагаж мөрдөх Монгол улсын албан ёсны анхны стандарт болно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.080.30; 07.040; 35.240.70

Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000.	MNS 6702:2017
Topographic and plan map database design, symbols. Scale: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000.	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Монгол улсын хэмжээнд 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн болон дэвсгэр зураг зохиох, шинэчлэх, хэвлэх үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгжүүд нь энэ стандартад орсон таних тэмдэг, загвар санг мөрдлөг болгоно.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах баримт бичгийг эшлэл болгож ашигласан бөгөөд, өөрчлөлт орох нь энэ стандартыг шинэчлэх үндэслэл шаардлага болохгүй. Үүнд:

- “Байр зүйн дэвсгэр зургийн томъёолсон тэмдэг - Масштаб 1:500, 1:1000, 1:2000, 1:5000” - 2001 он, Улсын Геодези, зураг зүйн газар;
- DGIWG Portrayal Standard for Multinational Geospatial Co-Production Program (MGCP) Data;
- MGCP Feature and Attribute Catalogue TRD3 v3.0;
- Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн загвар, кодчилал - 2010 он, ГХБГЗЗГ;
- “Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсөл”.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1 Газрын харилцааны салбарын хэмжил, зураглалд түгээмэл хэрэглэгддэг мэргэжлийн нэр, томъёо тодорхойлолт болон гадаад нэршлээрээ яриа болон бичгийн хэлбэрт нэгэнт хэрэглэгдэж хэвшсэн үгийг стандартад шууд тусган хэрэглэнэ.

3.2 Тэмдэг - Байр зүйн зургийн таних тэмдэг нь өөрийн код, дүрслэгдэх хэлбэр /цэг, шугам, талбай/-ээр илэрхийлэгдэх бөгөөд бусад төрлийн тэмдэгтэй хослон хэрэглэгддэг.

4 Норматив шаардлага

4.1 Байр зүйн зурагт дүрслэгдэх объектууд нь ангилал, кодтой байх ба тэдгээрийг өөр өөрийн гэсэн онцлогтой Тэмдгээр дүрсэлнэ.

4.2 Элементүүдийг дүрслэхдээ бусад төрлийн Тэмдэгтэй хослуулан үзүүлэхдээ хүснэгтэд үзүүлсэн жишээ зургийг ашиглана.

4.3 Элементийг хүснэгтэд үзүүлсний дагуу дүрсэлнэ.

4.3.1 Зарим өвөрмөц тэмдгийг цэгээр хүрээлэн хязгаарыг үзүүлнэ.

4.3.2 Объектын нэр болон тайлбарт хэрэглэх бичиглэлд хүснэгт болон стандартад тавьсан шаардлагыг мөрдөнө.

5 Таних тэмдэгт тавих ерөнхий шаардлага

5.1 Тэмдгийн хүснэгтэд бүх төрлийн байр зүйн зурагт заавал хэрэглэх Тэмдгийг үзүүлснээс гадна тухайн масштабын байр зүйн зурагт гол хэрэглэгдэх газар доорх шугам сүлжээ, усжуулалтын төхөөрөмжийн гэх мэт тэмдгийг хэрэглэнэ.

5.2 Байр зүйн зурагт Тэмдэг хоорондоо 0.3 мм-ээс багагүй зайтай байна.

5.3 Байр зүйн зураг дээр газар орны объектын байршил нь масштабын бус Тэмдгээр илэрхийлэгдэнэ.

5.3.1 Зөв дүрсээр илэрхийлэгдэх Тэмдэг (дугуй, тэгш өнцөгт, гурвалжин, таван хошуу гэх мэт) - **Тэмдгийн дүрсийн төв**;

5.3.2 Тусгацын дүрсээр илэрхийлэгдэх Тэмдэг (усны түвшин хэмжүүр, гэрэлт цамхаг, үлдэц хад гэх мэт) – **Тэмдгийн дүрсийн суурийн дундаж**;

5.3.3 Сууриндаа тэгш өнцөгт дүрсээр илэрхийлэгдэх Тэмдэг (модны төрөл, км-ын шон, ус хагалбарын суваг гэх мэт) – **Тэмдгийн дүрсийн өнцгийн орой**;

5.3.4 Хэд хэдэн дүрсээр Тэмдгээр илэрхийлэгдэх Тэмдэг (газрын тосны болон шатах хийн цамхаг, бунхан, сүм, цамхаг хэлбэрийн байгууламж, хадны марк) - **Тэмдгийн дүрсийн доод талын төв** тус тус байна.

5.4 Тэмдгийн хүснэгтийн зургууд нь тэдгээрийн хэмжээг мм-ээр илэрхийлсэн хэмжээтэй байна. Хэрэв хэмжээ хоёр байвал эхнийх нь Тэмдгийн өндрийг, хоёр дахь нь түүний өргөнийг илэрхийлнэ. Зургийн хажууд нэг хэмжээ өгөгдсөн бол өндөр, өргөн нь адил гэж тооцно. Зургийн хажууд хэмжээ өгөгдөөгүй бол Тэмдгийн хэмжээг хүснэгтийн зургаар тодорхойлно.

5.5 Бүх Тэмдгийн хэмжээ нь дундаж ачаалалтай байр зүйн зургийн жишгээр зохиогдоно.

5.6 Төмөр зам, зам дагуу байрлах гэрэлтүүлгийн шон зэргийг явж буй чиглэлийн дагуу тэнхлэгээр нь зураглана.

5.7 Хайс, хашааны эргэлт доголыг гадна талаас нь зураглана.

5.8 Талбай, ургамал, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, газрын гадаргын бичил тогтоц, намаг, хужир, марз, хөрс зэргийг үзүүлэх Тэмдэг хоорондын хүснэгтэд заасан зайг цэглэн хүрээлэх хэмжээг нь 25 см.кв болон түүнээс их бол 1.5 эсвэл 3 дахин ихэсгэж болно.

5.9 Энэхүү дөрвөн төрлийн масштабын зурагт байр зүйн объектууд нь хүснэгтэд ижил нэг Тэмдэгтэй (цооног, радио цамхаг, эргийн шугам, хүрхрээ, газрын эвдрэл, ургамал, задгай газар гэх мэт) байвал тайлбар бичиглэлийн хэмжээ хүснэгтэд үзүүлсэн загвар бичиглэлтэй ижил буюу масштаб бүрт өөр өөр байна.

5.10 Тодорхой салбарын хэрэгцээнд зориулсан байр зүйн зургийг эх хувиас нь захиалагчийн тогтоосон байдлаар (тусгай зориулалтын) бэлтгэн гүйцэтгэнэ.

6 Таних тэмдгийн бичиглэлд тавих шаардлага

6.1 Бүх төрлийн байр зүйн зурагт цагаан толгойн бүх үсэг, мөрөөр бичих үсгүүд, 10 хүртэлх тоон бичиглэл тэдгээрийн нэр, индекс, хэмжээ, гарчгийн үсэг зэргийг ашиглана.

6.2 Байр зүйн зурагт товчилсон үгийн ард цэг тавина. Хэд хэдэн үгийг товчилсон бол хооронд нь цэгээр хязгаарлаж зай авахгүй бичнэ.

6.3. Зургийн тайлбар бичиглэл "Arial", "Times New Roman" үсгийн 4.3-24 мм өндөртэй фонтоор бичнэ.

6.4 Байр зүйн зургийн чанарыг хангах, олшруулах болон багасгах, өсгөн томруулахад зориулан бичиглэлийн өндөр, өргөнийг өгөгдсөн хэмжээний 1/3-ээр ихэсгэх буюу багасгаж болно. Энэ зарчмыг хамгийн их буюу хамгийн бага ачаалалтай байр зүйн зурагт хэрэглэнэ.

6.5 Суурин газрын нэрийг зураглагдсан газрын баруун гар галд бичнэ. Хэрэв хот, суурин газрын талбай тухайн нэрэлбэр зургийн ихэнх хэсгийг эзэлж байвал тэдгээрийн нэрийг 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зургийн хойд хүрээнд байрлуулна.

6.6 Байр зүйн зурагт зураглах хот, суурин газрын нэрийг зөвхөн нэг хэмжээний бичиглэлээр өгнө. Хөдөөгийн суурин, зуслан зэрэгт тэдгээрийн оршин суугчдын тоог харгалзан 4 төрлийн бичиглэлийг хэрэглэж болно. Үүнийг үйлдвэрийн газар, төмөр замын буудал, усан зогсоол зэргийн нэрийг байр зүйн зурагт байрлуулахад түгээмэл хэрэглэдэг. Эдгээр нь хот маягийн сууринд тооцогддоггүй. Хүн ам шигүү, эсвэл хүн ам цөөнтэй орон нутагт хэрэглэгдэх нэрийг бичих, байрлуулахад /бичиглэлийн заавар 6.2.4/ баримтална.

6.7 Хэрэв суурин газар төвлөрсөн үйлдвэрийн объектууд өөрийн нэртэй бол нэрийг нь бичих бөгөөд шаардлагатай бол түүний дор нэмэлт тайлбар бичиглэл хийнэ.

6.8 Хэрэв суурин газар нь засаг захиргааны байгууллагатай бол түүний нэрийг суурины нэрийн дор бичиж байрлуулна. Захиргааны барилгын хажууд "сум. захирг.", "дүүр. захирг." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

6.9 Өргөн, нарийн гудамжны нэрийг тэдгээрийн тэнхлэг дагуу чиглэлтэй бичиж байрлуулна. Тухайн гудамж уулзвараар тасарч байвал дараагийн хэсэгт нэрийг мөн адил бичиж өгнө. Хэрэв гудамж гарцтай, зүлэгтэй, зурвасласан бут сөөгтэй бол аль зайтай гарц дээр нэрийг бичнэ.

6.10 Гол, горхи, ганга, жалга, суваг, шуудуу зэрэг үргэлжилсэн байгууламжийн нэрийг тэдгээрийн дүрслэл дагуу 15-20 см зайтай бичих бөгөөд гол, горхи, ганга жалгын эхлэлд мөн тэдгээртэй нийлсэн газар нэрийг бичиж байрлуулна. Усан тогтоц, арал, хясаа, газрын өндөр нам, намаг, өвөрмөц газар зэргийн нэрийг бүтнээр нь буюу хураангуйлсан байдлаар бичнэ. Тухайлбал: "Холбоо нуур", "Холб.н.", "Хэрлэн арал", "Хэрл.а."

MNS 6702:2017

6.11 Уул нуруу, говь цөл гэх мэт асар уудам талбай эзэлсэн байгалийн объектуудын нэрийг том масштабын байр зүйн зурагт бичих шаардлагагүй.

6.12 Газар дээрх объектуудын тоон тодорхойлолтыг (хаялбараас бусад) өгөхөөс гадна барилгын давхрын тоог налуугүй бичиглэлээр бичнэ.






6.13 Тэмдгийн тайлбар бичиглэл, үзүүлэлт нь тэдгээрийн нэг үндсэн хэсэг бөгөөд байр зүйн зургийн объектуудыг зураглахад зайлшгүй мөрдөгдөнө. Тайлбар бичиглэл, үзүүлэлтийг зураглагдсан объектын баруун талд Тэмдэг багатай, зай бүхий газар бичиж байрлуулна. Байр зүйн зурагт тайлбар бичиглэл хийх зайнаас хамааран тайлбар бичиглэлийг бүтнээр буюу хураангуйлсан байдлаар өгнө. Үүнд хоёр хувилбар байдаг. Тухайлбал: "Хэрлэн" (тогтоосон нэр) "Хэр.", "Модны" (тайлбар) "Мод." эсвэл "М"

6.14 Байр зүйн зурагт хэрэглэгдэх хураангуйлсан үгийг "Хураангуйлан бичих заавар"-ын дагуу хэрэглэнэ. Хураангуйлсан үг нь 3-аас доошгүй үсэгтэй байна.

6.15 Байр зүйн зургийн хүрээний хойд ба доод хэсэгт бичигдэх бичиглэл, үндсэн бичиглэл байна. Зургийн хүрээний баруун, зүүн талд бичиглэл хийдэггүй.

6.16 Байр зүйн зургийн масштаб, зураглалын талбайтай уялдуулан тогтсон нэрэлбэр буюу дугаарыг өгнө.










7 Таних тэмдэг

д/д	код	Газрын гадаргын элементийн нэр	Дүрслэх хэлбэр	Масштаб 1:500-1:1000	Масштаб 1:2000-1:5000
Геодезийн цэг тэмдэгт					
1	G101_P	Одон орны цэг	цэг		
2	G102_P	GNSS-ийн байнгын ажиллагаатай станц	цэг		
3	G103_P	GPS-ийн сүлжээний цэг	цэг		
4	G104_P	Триангуляцийн сүлжээний цэг	цэг		
5	G105_P	Полигонометрийн сүлжээний цэг	цэг		
6	G106_P	Гравиметрийн сүлжээний цэг	цэг		
7	G107_P	Өндрийн сүлжээний цэг	цэг		
8	G108_P	Зураглалын сүлжээний цэг	цэг		
9	G101_T	Цэг тэмдэгтийн дугаар, өндөр	үсэг	<u>ГЦТ 0089</u> 777.9	
Авто зам					
10	A101_L	Хурдны зам	шугам		
11	A102_L	Засмал зам	шугам		
12	A103_L	Сайжруулсан зам	шугам		
13	A104_L	Хөрсөн зам	шугам		



14	A105_L	Баригдаж буй зам	шугам		
15	A106_L	Жим	шугам		
16	A107_L	Авто замын тэнхлэгийн шугам	шугам		
17	A108_A	Авто зам	талбай		
18	A102_T	Авто замын дугаар, үзүүлэлт	үсэг	-	8.0x2(24.5)Б

Зам түүний байгууламж






19	A201_A	Явган хүний зам, талбай	талбай		
20	A202_A	Явган хүний гүүрэн гарц	талбай		
21	A203_A	Хонгил /туннель/	талбай		-
22	A203_L	Хонгилын /туннели/ орц, гарц	шугам		-
23	A203_P	Хонгил /туннель/	цэг	-	
19	A201_A	Гүүр	талбай		






					
25	A204_L	Гүүр	шугам		
26	A204_P	Гүүр	цэг	-	
27	A205_L	Замын хашилт	шугам		-
28	A206_P	Замын хаалт	цэг		-
29	A207_L	Самбар	шугам	 самб.	
30	A208_P	Замын сурталчилгааны самбар	цэг		-
31	A209_L	Замын нуман хаалга	шугам		-
32	A210_A	Дугуйн зам	талбай		-
33	A211_A	Гүйлтийн зам	талбай		-
34	A212_A	Ус зайлуулах хоолой	талбай		-
35	A212_L	Ус зайлуулах хоолой	шугам	-	
36	A213_P	Төлбөр авах цэг	цэг		-
37	A202_T	Замын байгууламжийн тайлбар бичиглэл	үсэг	төм. бет. ТБ.	явг. Ч.
38	A205_T	Замын байгууламжийн үзүүлэлт	үсэг		

Замын элемент





39	A301_A	Явган хүний замын гарц	талбай		0.12
40	A302_A	Аюулгүйн бүс	талбай		0.12
41	A303_A	Авто зогсоолын хил	талбай		0.12
42	A304_P	Авто зогсоолын тэмдэг	цэг		1.5
43	A305_P	Автобусны зогсоол	цэг		1.5
44	A306_P	Таксины зогсоол	цэг		1.5
45	A307_P	Замын гэрлэн дохио	цэг		-
46	A308_P	Замын тэмдэг	цэг		-
47	A309_P	Троллейбусны шон	цэг		-
48	A310_P	Замын км-ийн тэмдэг	цэг		-
49	A311_L	Хурд сааруулагч	шугам		-
50	A312_P	Хурд хэмжигч	цэг		-
51	A313_L	Авто замын тусгаарлагч цагаан шугам	шугам		0.2








Төмөр зам

52	A401_L	Төмөр зам	шугам		
53	A402_L	Баригдаж буй төмөр зам	шугам		
54	A403_L	Төмөр замын тэнхлэгийн шугам	шугам		0.3

55	A404_P	Төмөр замын зам шилжүүлэгч	цэг		-
56	A405_A	Төмөр замын тавцан	талбай		
57	A406_P	Гэрлэн дохиолуур	цэг		-
58	A407_P	Анхааруулгын самбар	цэг		-
59	A408_L	Төмөр замын төгсгөл	шугам		
60	A401_T	Төмөр замын тайлбар бичиглэл	үсэг	нар.	нар.

Барилга

61	B101_A	Энгийн байр, орон сууц	талбай		
62	B102_A	Орон сууцны бус барилга	талбай		
63	B103_P	Барилга /масштабын бус/	цэг	-	
64	B104_A	Баригдаж буй	талбай		-
65	B105_P	Нурсан барилга	цэг	-	
66	B105_A	Нурсан барилга	талбай		
67	B106_P	Цамхаг хийцийн барилга	цэг		
68	B107_A	Авто гараж	талбай		-

69	B108_P	Хүлэмж	цэг	-	16 
70	B108_A	Хүлэмж	талбай		-
71	B109_P	Зоорь	цэг	-	1.5 1.5 3.0 
72	B109_A	Зоорь	талбай	 зоорь	 зоорь
73	B110_P	Саравч, сүүдрэвч, асар	цэг	  	16  16
74	B110_A	Саравч, сүүдрэвч, асар	талбай		
75	B111_P	Шат, довжоо, орц гарц	цэг	-	12  1.5
76	B111_L	Шат, довжоо, орц гарц	шугам	  	-
77	B112_A	Хаяавч	талбай		-
78	B113_A	Багана	талбай	 0.12	-
79	B113_P	Багана	цэг	 2.0	 1.0
80	B114_A	Нуман хаалган гарц	талбай		-
81	B114_L	Нуман хаалган гарц	шугам	-	
82	B115_L	Түймрийн шат	шугам		-
83	B116_P	Туг	цэг	 3.5	-
84	B117_A	Хороолол, хотхон	талбай	-	 0.12
85	B118_A	Газар доорх барилга, байгууламж	талбай	 1.5 1.0	-
86	B119_P	Гэр /өвөлжөө, хаваржаа/	цэг	 1.2 3.0	-

87	B120_A	Агааржуулагч	талбай	0.12	-
88	B101_T	Барилга, байгууламжийн материал, давхар	үсэг	2М, 3Т	
89	B102_T	Барилга, байгууламжийн тайлбар бичиглэл	үсэг	барь. нур. зоорь. барим. хөш.	барь. хүл. 3ЦХ.
90	B100_T	Барилга, байгууламжийн хаяг	тоо	805	408

Олон нийтийн байгууллага

91	B201_P	Нийслэл хотын захиргаа	цэг	● 2.2	
92	B202_P	Хот, Аймгийн захиргаа	цэг	◐ 2.2	
93	B203_P	Сум, Дүүргийн захиргаа	цэг	◑ 2.2	
94	B204_P	Баг, Хорооны байр	цэг	◒ 2.2	
95	B205_P	Төрийн байгууллага	цэг	Ⓐ 2.0	-
96	B206_P	Эрүүл мэндийн төв	цэг	⊕ 2.0	-
97	B207_P	Шүүх байгууллага	цэг	Ⓢ 2.0	-
98	B208_P	Прокурорын газар	цэг	Ⓣ 2.0	-
99	B209_P	Цагдаагийн газар	цэг	Ⓟ 2.0	-
100	B210_P	Цагдаагийн хэлтэс	цэг	Ⓠ 2.0	-
101	B211_P	Шорон буюу хорих газар	цэг	Ⓡ 2.0	-
102	B212_P	Гал командын газар	цэг	Ⓢ 2.0	-
103	B213_P	Татварын газар	цэг	Ⓣ 2.0	-
104	B214_P	Гаалийн газар	цэг	Ⓡ 2.0	-
105	B215_P	Шуудан	цэг	Ⓢ 2.0	-
106	B216_P	Цаг уурын газар	цэг	Ⓣ 2.0	-
107	B217_P	Цахилгаан холбоо буюу телефон ашиглалтын газар	цэг	Ⓢ 2.0	-
108	B218_P	Нийгмийн халамжийн төв	цэг	Ⓢ 2.0	-
109	B219_P	Хүүхдийн төв	цэг	Ⓢ 2.0	-

Соёл, боловсролын байгууллага

110	B301_P	Сургууль	цэг	Р 2.0	-
111	B302_P	Хүүхдийн цэцэрлэг, ясли	цэг	☺ 2.0	-
112	B303_P	Номын сан	цэг	☹ 2.0	-
113	B304_P	Сургалтын төв (дамжаа)	цэг	© 2.0	-
114	B305_P	Дотуур байр	цэг	☹ 2.0	-
115	B306_P	Биеийн тамирын заал	цэг	⊕ 2.0	-
116	B307_P	Буддын хийд	цэг	▲ 2.2 2.0	-
117	B308_P	Христос сүм	цэг	⊕ 2.0	-
118	B309_P	Лалын шашны сүм	цэг	2.5 1	-
119	B310_P	Католик шашны сүм	цэг	⊕ 2.0	-
120	B311_P	Бунхан суварга	цэг	2.2 1.0	-
121	B312_P	Музей	цэг	Ⓜ 2.0	-
122	B313_P	Уран зургийн галерей	цэг	☹ 2.0	-
123	B314_P	Соёлын төв	цэг	Ⓜ 2.0	-
124	B315_P	Телевизийн нэвтрүүлгийн газар	цэг	↑ 2.0	-
125	B316_P	Радио нэвтрүүлгийн газар	цэг	↑ 2.0	-
126	B317_P	Сонины газар	цэг	Ⓜ 2.0	-
127	B318_P	Сэтгүүлийн газар	цэг	☹ 2.0	-
128	B319_P	Театр	цэг	☹ 2.0	-
129	B320_P	Хүүхдийн халамжийн төв	цэг	☹ 2.0	-
130	B321_P	Хөшөө баримал	цэг	2.0 1.2	-
131	B322_P	Мөнхийн гал	цэг	ψ 2.0	-

Үйлчилгээний байгууллага

132	B401_P	Зочид буудал	цэг	Ⓜ 2.0	-
133	B402_P	Дэн буудал	цэг	Ⓜ 2.0	-

134	B403_P	Амралтын газар	цэг	 2.0	-
135	B404_P	Нийтийн халуун усны газар	цэг	 2.0	-
136	B405_P	Банк	цэг	 2.0	-
137	B406_P	Даатгалын компани	цэг		-
138	B407_P	Галт тэрэгний буудал, өртөө	цэг	 2.0	
139	B408_P	Хот хоорондын авто вокзал	цэг		
140	B409_P	Нисэх онгоцны буудал	цэг	 2.0	
141	B410_P	Шатахуун түгээгүүр	цэг		
142	B411_P	Авто засварын газар	цэг		-
143	B412_P	Авто угаалгын газар	цэг		-
144	B413_P	Эмнэлэг	цэг	 2.0	-
145	B414_P	Эмийн сан	цэг	 2.0	-

Үйлдвэр, худалдаа







146	B501_P	Үйлдвэр	цэг	 2.5	
147	B502_P	Цахилгаан станц	цэг	 3.5	
148	B503_P	Дэд станц /ТП, РП/	цэг	 2.8	
149	B504_P	Хувьсгуур /трансформатор/	цэг	 3.0	
150	B505_P	Их дэлгүүр /март/	цэг		-
151	B506_P	Дэлгүүр	цэг		-
152	B507_A	Худалдааны захын хил	талбай	 0.12	
153	B507_P	Худалдааны захын тэмдэг	цэг		
154	B508_P	Аж үйлдвэрийн хаягдал цэвэрлэх байгууламжийн тэмдэг	цэг	 2.0	-
155	B509_P	М.А.А-н хаягдал цэвэрлэх байгууламжийн тэмдэг	цэг	 2.0	-
156	B510_P	Бохир ус цэвэрлэх байгууламжийн тэмдэг	цэг	 2.0	-
157	B511_P	Ус шавхах\түгээх байгууламжийн тэмдэг	цэг		

158	B512_A	Ус шавхах/түгээх байгууламжийн хил	талбай	 0.12
-----	--------	------------------------------------	--------	--




Амралт, тоглоом


159	B601_P	Хүүхдийн тоглоомын газар	цэг	
160	B602_P	Спортын талбайн тэмдэг	цэг	
161	B603_A	Спортын талбайн шаталсан суудал	талбай	 1.5
162	B604_P	Халуун рашаан	цэг	
163	B605_A	Цэцэрлэгт хүрээлэнгийн хил	талбай	 0.12
164	B606_P	Загасчлах газар	цэг	
165	B607_P	Гольфийн талбайн тэмдэг	цэг	
166	B608_P	Газрын теннисний талбайн тэмдэг	цэг	
167	B609_P	Цанын талбайн тэмдэг	цэг	
168	B610_P	Усан бассейны тэмдэг	цэг	
169	B611_P	Наран шарлагын газар	цэг	 2.5

Хашаа









170	B701_L	Банз буюу модон хашаа	шугам	 0.12	 0.12
171	B702_L	Бетон чулуун хашаа	шугам	 0.12	 0.12
172	B703_L	Төмөр хашаа	шугам	 0.12	 0.12
173	B704_L	Төмөр торон хашаа	шугам	 0.12	 0.12
174	B705_L	Жижиг хашаа /хайс/	шугам	 0.12	 0.12
175	B706_L	Малын хашаа	шугам	 0.12	
176	B706_P	Малын хашаа	цэг	-	 2.0
177	B707_L	Хашааны хаалга /орц, гарц/	шугам	 0.3	-
178	B701_T	Хашааны хаяг	үсэг	Энх тайвны өргөн чөлөө, 42	-









Аж үйлдвэрийн байгууламж

179	C101_A	Объект, элементийн хил	талбай	 0.12	
180	C102_P	Яндан	цэг	-	 0.3 1.2
181	C102_A	Яндан	талбай	 0.12	-
182	C103_P	Уурхайн үндсэн амсар	цэг	 2.0 3.0 3.0	-
183	C104_P	Уурхайн туслах амсар, цооног	цэг	 1.5 2.0 2.0	-
184	C105_P	Хаагдсан уурхай, орд газар	цэг	46  2.0	
185	C106_L	Уул уурхай, орд газар /ил уурхай/	шугам		
186	C107_P	Геологи хайгуулын шуудууны амсар, цооног	цэг	 0.3 2.0  0.4 3.0  1.5 2.5 1.2	-
187	C107_L	Геологи хайгуулын шуудуу	шугам	 геол.	
188	C108_P	Газрын тосны цамхаг	цэг	 10 5.0 2.0 1.5	 5.0 1.5
189	C109_P	Хийн цамхаг	цэг	 2.0 0.5	
190	C110_P	Газрын тосны худаг	цэг	 1.5	
191	C111_P	Газрын тосны ай сав газар	цэг	-	 2.0
192	C111_A	Газрын тосны ай сав газар	талбай		-
193	C112_P	Агуулах /сав/	цэг	-	 2.0 ган.
194	C112_A	Агуулах /сав/	талбай		-


195	C113_P	Машин засварын тавцан	цэг	-	
196	C113_L	Машин засварын тавцан	шугам		
197	C114_P	Өргөгч цамхаг /кран/-ын тэмдэг	цэг		-
198	C115_P	Зөгий үржүүлэг	цэг		-
199	C101_T	Аж үйлдвэрийн байгууламжийн тайлбар бичиглэл	үсэг	янд. газ.тос. геол.	ган. хүчил. цоон.

Цахилгаан, холбооны байгууламж

200	C201_P	Шон	цэг		
201	C201_L	Татанги	шугам		-
202	C202_P	Гэрлийн шон	цэг		
203	C203_P	Гэрэлтүүлэг	цэг		-
204	C204_P	Цахилгааны худаг	цэг		
205	C204_L	Цахилгаан дамжуулах шугам /өндөр хүчдэл/	шугам		
206	C205_L	Цахилгаан дамжуулах шугам /нам хүчдэл/	шугам		
207	C206_L	Цахилгаан дамжуулах шугам /газар доорх, өндөр хүчдэл/	шугам		
208	C207_L	Цахилгаан дамжуулах шугам /газар доорх, нам хүчдэл/	шугам		
209	C208_P	Холбооны худаг	цэг		
210	C208_L	Холбооны шугам /газар дээрх/	шугам		

211	C209_L	Холбооны шугам /газар доорх/	шугам		
212	C210_P	Шилэн кабелийн худаг	цэг	± 1.5	
213	C210_L	Шилэн кабель /газар дээрх/	шугам		
214	C211_L	Шилэн кабель /газар доорх/	шугам		
215	C212_P	Телевиз, радиогийн цамхаг /антен/	цэг		
216	C213_P	Үүрэн холбооны антен	цэг		
217	C214_P	Аянга зайлуулагч /шон дээрх/	цэг		
218	C215_P	Салхин сэнс	цэг		
219	C216_P	Нарны зай хураагуур	цэг		
220	C217_P	Нийтийн харилцуур утас /таксфон/	цэг	± 2.0	-
221	C218_P	Телефон хуваарилалтын шүүгээ	цэг		-
222	C219_P	Хяналтын камер	цэг		-
223	C220_P	Хяналтын камерын худаг	цэг		-
224	C221_P	Холын гэрэлтүүлэг	цэг		-
225	C222_P	Нисэх онгоцны зурвасын гэрэл	цэг		-
226	C223_P	Налуу заагч гэрэл	цэг		-
227	C224_P	Тоон ажиглалтын систем	цэг		-
228	C225_A	Антенн /бусад/	талбай		-
229	C200_T	Цахилгаан, холбооны байгууламжийн бичиглэл	үсэг	каб. эвд.	-
230	C201_T	Цахилгаан, холбооны байгууламжийн үзүүлэлт	үсэг	8 вт	-



Шугам сүлжээ






231	C301_P	Цэвэр усны худаг	цэг	$\ominus 1.8$	-
232	C301_L	Цэвэр усны шугам /газар дээрх/	шугам	 0.12	-
233	C302_L	Цэвэр усны шугам /газар доорх/	шугам	 0.12	-
234	C303_P	Дулааны худаг	цэг	$\oplus 1.8$	-
235	C303_L	Дулааны шугам /газар дээрх/	шугам	 0.12	-
236	C304_L	Дулааны шугам /газар доорх/	шугам	 0.12	-
237	C305_P	Ариутгах татуургын худаг	цэг	$\oplus 1.8$	-
238	C305_L	Ариутгах татуургын шугам /газар доорх/	шугам	 0.12	-
239	C306_P	Үерийн усны худаг	цэг	$\ominus 1.8$	-
240	C306_L	Үерийн усны шугам /газар дээрх/		 0.15	-
241	C307_L	Үерийн усны шугам /газар доорх/		 0.15	-
242	C308_L	Уурын хоолой /газар дээрх/	шугам	 0.12	-
243	C309_L	Уурын хоолой /газар доорх/	шугам	 0.12	-
244	C310_P	Бусад худаг	цэг	$\emptyset 1.8$	-
245	C310_L	Бусад шугам сүлжээ /газар дээрх/	шугам	 0.12	-
246	C311_L	Бусад шугам сүлжээ /газар доорх/	шугам	 0.12	-
247	C314_P	Яндан хоолойн тулгуур	цэг	$\boxtimes 1.0$	-
248	C313_A	Яндан хоолойн хорго	талбай	 0.12	-
249	C301_T	Цэвэр усны худгийн үзүүлэлт	үсэг	1230.5	-
250	C303_T	Дулааны худгийн үзүүлэлт	үсэг	1321.3.	-
251	C305_T	Ариутгах татуургын худгийн үзүүлэлт	үсэг	855.9	-
252	C306_T	Үерийн усны худгийн үзүүлэлт	үсэг	1020.1.	-
253	C310_T	Шугам сүлжээний тайлбар бичиглэл	үсэг	бет. ДЦ.	-





Ус, цаг уур









254	C401_P	Салхины хурд, чиглэл заагч	цэг		-
255	C402_P	Даралт температур, чийг хэмжигч	цэг		-
256	C403_P	Хур тунадас хэмжигч	цэг		-
257	C404_P	Үүлний өндөр хэмжигч	цэг		-
258	C400_T	Ус, цаг уурын элементийн тайлбар бичиглэл	үсэг	ус цаг уур	


Ус зүй

259	E101_A	Гол	талбай	
260	E101_L	Гол /нарийн/	шугам	
261	E102_A	Ширгэдэг гол	талбай	
262	E102_L	Ширгэдэг гол /нарийн/	шугам	
263	E103_A	Нуур	талбай	
264	E104_A	Нуур /ширгэдэг/	талбай	
265	E105_L	Голын тэнхлэгийн шугам	шугам	
266	E106_P	Усны түвшний тоот	цэг	
267	E107_A	Шургадаг гол	талбай	
268	E107_L	Шургадаг гол /нарийн/	шугам	
269	E108_L	Урсгал усны чиглэл	шугам	
270	E109_P	Булаг, шанд	цэг	




271	E110_P	Рашаан	цэг		
272	E111_A	Намаг /гаталдаггүй/	талбай		
273	E112_A	Намаг /гаталдаг/	талбай		
274	E113_P	Намгархаг газар	цэг		
275	E114_A	Марз /гаталдаггүй/	талбай		
276	E115_A	Марз /гаталдаг/	талбай		
277	E116_L	Хүрхрээ	шугам		_____ 0.2
278	E117_L	Боргио	шугам	 борг.	_____ 0.2
279	E118_A	Харгиа	талбай	 харг.	-
280	E119_P	Усан сан	цэг	-	1.5: 

Усны байгууламж				
288	E201_P	Худаг /гар, ховоотой/	цэг	
289	E202_P	Худаг /мотортой/	цэг	
290	E203_P	Худаг /эргүүлдэг/	цэг	
291	E204_P	Худаг /дүүжинтэй/	цэг	
292	E205_P	Усан оргилуур	цэг	
293	E205_A	Усан оргилуур	талбай	
294	E206_P	Усны сав /тулгуур дээрх/	цэг	
295	E206_A	Усны сав /тулгуур дээрх/	талбай	
296	E207_L	Гатлага	шугам	
297	E208_L	Гарам, олом	шугам	
298	E209_P	Ус сорох байгууламж	цэг	
299	E210_P	Усны цорго	цэг	
300	E211_P	Усны цорго /түймэр, усалгааны зангилаа/	цэг	




301	E212_L	Ус хуваарилах байгууламж	шугам		-
302	E213_L	Эргийн хаалт, хашлага	шугам		
303	E214_A	Усан онгоцны зогсоол /тавцан/	талбай		
304	E214_P	Усан онгоцны зогсоол	цэг		
305	E215_P	Гэрэлт цамхаг	цэг		
306	E216_P	Гэрэлт цамхаг /хөвдөг/	цэг		
307	E217_P	Гэрэлтүүлэгч гал	цэг		
308	E218_P	Эрэг дэх дохиоллын тэмдэг	цэг		
309	E219_P	Усан замын хөвүүр тэмдэг	цэг		
310	E201_T	Худгийн нэр	үсэг	Сайн усны худаг Х. бул.	
311	E202_T	Худгийн үзүүлэлт	тоо	500л/ц	
312	E206_T	Усны байгууламжийн тайлбар	үсэг	ган. бет. чул.	

313	E208_T	Олом, гарамны үзүүлэлт	тоо	
-----	--------	------------------------	-----	---

Мөнх цас, мөсөн гол

314	E301_L	Мөсөн гол /Тодруулсан шугам/	шугам	
315	E302_L	Мөсөн гол /Үндсэн шугам/	шугам	
316	E303_L	Мөсөн гол, хөр цасны хүрээ	шугам	
317	E304_L	Мөсөн ангал	шугам	
318	E305_P	Мөсөн худаг	цэг	
319	E306_A	Хөр цас, хунгар	талбай	
320	E307_L	Мөсөн ханан хад	шугам	
321	E306_T	Мөнх цас, мөсөн голын бичиглэл	үсэг	дошин.

Газрын гадарга






322	F101_L	Хаялбарын шугам (Тодруулсан шугам)	шугам	
323	F102_L	Хаялбарын шугам (Үндсэн шугам)	шугам	
324	F103_L	Хаялбарын шугам (Нэмэлт шугам)	шугам	
325	F104_L	Хаялбарын шугам (Туслах шугам)	шугам	

326	F105_L	Ус хагалбарын шугам	шугам	
327	F106_P	Өндрийн цэг	цэг	
328	F107_L	Жалга	шугам	
329	F108_A	Сайр	талбай	
330	F108_L	Сайр	шугам	
331	F109_P	Даваа	цэг	
332	F110_L	Эрэг /хаялгатай/	шугам	
333	F111_L	Эрэг, ганга, гуу	шугам	
334	F112_L	Ханан хад	шугам	
335	F113_P	Үлдэц цохио	цэг	
336	F114_P	Нүх	цэг	
337	F114_L	Нүх	шугам	
338	F115_P	Дов /хаялбраар дүрслэгдэхгүй/	цэг	
339	F116_P	Агуй нүхний амсар	цэг	
340	F117_P	Сондгой хад	цэг	

341	F118_L	Сэврэй хад	шугам		
342	F119_L	Галт уулын тогоо	шугам		
343	F120_L	Шавар рашааны тогоо	шугам		
344	F121_L	Чулуу	цэг		-
345	F122_L	Хөмөг	шугам		
346	F123_L	Мөргөцөг	шугам		
347	F124_L	Нурангитай газар	шугам		
348	F125_L	Усны хаялбар	шугам		
349	F101_T	Хаялбарын өндөр	тоо		
350	F106_T	Өндрийн тоо	тоо		
351	F107_T	Даваа, жалга, сайрын нэр	үсэг	<i>Солонготын даваа</i>	<i>Айдасын даваа</i>
352	F110_T	Жалга, сайр, эрэг, нүх, довны үзүүлэлт	тоо	3.5	1.3
353	F113_T	Даваа, үлдэц цохио, хадны үзүүлэлт	тоо	$\frac{4338.2}{V-IX}$ 3.2	$\frac{2354.5}{V-IX}$ 5.1

Хөрс, газрын бичил гадарга


354	F201_A	Элс	талбай		
-----	--------	-----	--------	--	--

355	F201_P	Элстэй газрын тэмдэг	цэг	-	
356	F202_A	Бутархай хайрга, чулуу	талбай		
357	F203_A	Шал	талбай		
358	F204_A	Шаварлаг гадарга	талбай		Цэгийн өргөн 0.4 мм
359	F205_A	Чулуу, хайрга	талбай		
360	F206_L	Чулуутай сайр	шугам		
361	F207_A	Ургаа чулуу	талбай		
362	F208_A	Довцог гадарга	талбай		


363	F209_A	Дов, сондуултай гадарга	талбай	
-----	--------	-------------------------	--------	--

Газрын гадарга дээрх байгууламж

364	F301_A	Далан	талбай	
365	F301_L	Далан	шугам	
366	F302_L	Далан /масштабд илэрхийлэгдэхгүй/	шугам	
367	F303_L	Үерийн усны суваг, шуудуу	шугам	
368	F304_L	Үерийн усны суваг, шуудуу /газар доорх/	шугам	
369	F305_P	Хиргисүүр	цэг	
370	F305_L	Хиргисүүр	шугам	
371	F306_L	Овоолго шороо, ухсан нүх	шугам	
372	F306_P	Овоолго шороо, ухсан нүх	цэг	
373	F307_P	Овоо	цэг	
374	F308_P	Оршуулгын газар	цэг	









375	F308_A	Оршуулгын газар	талбай	
376	F309_P	Эртний дурсгалт газар (туурь)	цэг	$\begin{matrix} \dots 1.2 \\ 0.7 \end{matrix}$
377	F310_L	Эртний хана хэрэм	шугам	$\begin{matrix} 1.0 \\ \text{---} \end{matrix} \dots 0.8$
378	F301_T	Далан, суваг, шуудууны үзүүлэлт	тоо	$\frac{1.5}{0.4} \quad 1.4$
379	F307_T	Газрын гадарга дээрх байгууламжийн тайлбар бичиглэл	үсэг	$\begin{matrix} \text{хиргис.} & \text{агуй.} & \text{галт} \\ \text{уул.} & \text{бет.} & \text{чул.} \end{matrix}$


Ургамал зүй

380	D101_A	Ой	талбай	
381	D102_L	Ургамлын хүрээ, хил	шугам	$\begin{matrix} 1.0 \\ \text{---} \end{matrix} \dots 0.2$
382	D103_P	Ойд зонхилох мод	цэг	$\begin{matrix} \text{---} 3.5 & \text{---} 3.5 \\ 2.0 & 2.0 \end{matrix}$
383	D104_P	Холимог ойн тэмдэг	цэг	$\begin{matrix} \text{---} 3.5 & \text{---} 3.5 \\ 4.5 & 4.5 \end{matrix}$
384	D105_A	Бүдүүн голчтой мод	талбай	$\begin{matrix} \text{хус} & \text{---} 8 \\ \text{шинэс} & 0.07 \end{matrix} 5$
385	D106_A	Зулзаган мод	талбай	$\begin{matrix} \text{хус} & \text{---} 2 \\ \text{шинэс} & 0.04 \end{matrix} 4$
386	D107_A	Муруй мод	талбай	$\begin{matrix} \text{хус} & \text{---} 12 \\ \text{шинэс} & 0.15 \end{matrix} 5$









387	D108_A	Ширэнгэ ой	талбай		
388	D109_L	Ойн зурвас	шугам		
389	D110_A	Бүдүүн голчтой модтой сийрэг ой	талбай		
390	D111_A	Зулзаган мод зонхилдог сийрэг ой	талбай		
391	D112_A	Дархи	талбай		
392	D113_A	Шатсан хуурайшсан ой	талбай		
393	D114_A	Огтолсон ой	талбай		


394	D115_P	Мод	цэг	
395	D116_P	Өвс, ургамал	цэг	
396	D117_A	Бут, сөөг	талбай	
397	D118_A	Бут, сөөг /ширэнгэ/	талбай	
398	D119_A	Өргөст бут, сөөг	талбай	
399	D120_A	Өргөст бут, сөөг /ширэнгэ/	талбай	
400	D121_A	Сөөгхөн	талбай	
401	D122_A	Сөөгхөн /тачир/	талбай	

402	D123_A	Нугын ургамал	талбай	
403	D124_A	Сахлаг ургамал	талбай	
404	D125_A	Тачир ургамал	талбай	
405	D126_A	Зэгс, хулсны төрлийн ургамал	талбай	
406	D127_A	Тал хээрийн ургамал	талбай	
407	D128_A	Заг /ширэнгэ/	талбай	
408	D129_A	Хөвд	талбай	
409	D130_A	Хаг, хагдны төрлийн ургамал	талбай	



410	D131_A	Мөлхөө ургадаг модлог ургамал	талбай		
411	D132_P	Замаг	цэг		
412	D133_P	Усны ургамал	цэг		
413	D101_T	Ургамлын тайлбар бичиглэл	үсэг	<i>нарс. шинэс. бут.</i>	<i>нарс. хус. бут.</i>
414	D103_T	Модны үзүүлэлт, тайлбар	тоо	$\frac{8}{0.07}^5$	$\frac{15}{0.18}^4$

Таримал ургамал





415	D201_A	Ногооны талбай	талбай	 0.12	-
416	D202_A	Тариан талбай	талбай	 0.12	
417	D203_A	Жимсний цэцэрлэг	талбай		
418	D204_A	Жимсгэнэ	талбай		
419	D205_A	Жимс, жимсгэнийн цэцэрлэг	талбай		
420	D206_A	Мод, жимс үржүүлгийн газар	талбай		

421	D207_A	Техникийн ургамал	талбай		
422	D208_A	Атар газар	талбай		
423	D201_T	Таримал ургамлын тайлбар бичиглэл	үсэг	хус шинэс мод.үрж.г аз	алим. үржүүл.

Хот тохижилт

424	D301_P	Цэцгийн мандал	цэг		
425	D301_A	Цэцгийн мандал	талбай		
426	D302_A	Зүлэг	талбай		
427	D303_P	Зам дагуух мод	цэг	○ 1.0 ○ 1.5 ○ 1.8	○ 0.8 ○ 1.0 ○ 1.5
428	D303_L	Мод суулгасан зурвас	шугам	○ ○ ○ ○ ○ ○ ○ 1.5	○ ○ ○ ○ ○ ○ ○ 1.0
429	D304_P	Бут /зам дагуух/	цэг		
430	D304_L	Бут, сөөгний зурвас	шугам		

Засаг захиргааны хил

431	H101_L	Улсын хил	шугам		
432	H102_L	Аймаг, нийслэлийн хил	шугам		
433	H103_L	Сум, дүүргийн хил	шугам		
434	H104_L	Баг, хорооны хил	шугам		

435	H105_L	Тусгай хамгаалалттай газрын хил	шугам	
436	H101_P	Хилийн тэмдэгт	цэг	
437	H101_T	Хилийн тэмдэгтийн дугаар	тоо	999

8 Таних тэмдгийн тайлбар, түүнд тавигдах шаардлага

8.1 Геодезийн цэг тэмдэгт

8.1.1 Улсын геодезийн сүлжээний цэг тэмдэгт нь Засгийн газрын 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицол өндрийн нэгдсэн тогтолцоонд, ГХГЗЗГ-ын даргын 2014 он А/112 дугаар тушаалаар баталсан ITRF 2008 эринд тодорхойлсон одон орон, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, GPS, триангуляци, полигонометр, трилатераци, гравиметр, өндрийн, зураглалын сүлжээний цэг байна.

8.1.2 Удаан хугацаагаар ашиглагдахаар бэхэлсэн сүлжээний цэгт төмөр бетон тэмдэгт, зам төмөр, бетондсон төмөр, яндан хоолой зэрэг багтана. Түр хугацаагаар ашиглах цэгт модон шон, гадас, бетонодоогүй төмөр зэрэг орно.

8.1.3 Байр зүйн зурагт солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд тодорхойлогдсон Улсын геодезийн сүлжээний бүх цэг тэмдэгт болон геодезийн өтгөрүүлэлтийн сүлжээний цэг тэмдэгт, байр зүйн зураглалын ажлын цэгүүдийг масштабын бус Тэмдгээр дүрслэн үзүүлнэ.

8.1.4 Улсын геодезийн сүлжээний цэг тэмдэгт /цаашид Цэг гэх/ бүрт түүний дугаар ба өндрийг бичнэ.

8.1.5 Үлдэц цохион дээрх Цэгийг уг хад-цохионы хамт зурна. Байр зүйн зурагт зайг ашиглан үлдэц хад-цохион дээрх Цэгийн Тэмдгийн дэргэд үлдэц хадны үнэмлэхүй өндөр, эсвэл түүний ёроолын газрын өндрийн тоотыг бичнэ. Харин үлдэц хад-цохионы хадны ёроол нь бутархай чулуугаар бүрхэгдсэн бол өндрийн тоот бичихгүй.

8.1.6 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

1. /G101_P/. Одон орны хэмжилт, ажиглалтаар уртраг, өргөрөг, зовхис нь тодорхойлогдсон цэгийг уг давхаргад оруулж зурна. Одон орны цэгийг геодезийн сүлжээний эгнээний төгсгөлд тодорхойлж болно.

2. /G102_P/. Антеныхаа солбицол, өндрийг өндөр нарийвчлалтай тодорхойлсон, 24 цагийн турш олон улсын хиймэл дагуулаас өгөгдөл хүлээн авч тасралтгүй ажилладаг, 2 долгионы байрлал тодорхойлох иж бүрдлийг GNSS-ийн байнгын ажиллагаатай станц гэдэг. Уг байнгын ажиллагаатай станц нь байшингийн дээвэр болон багана дээр бэхлэгдсэн байна.

3-5. /G103_P - G105_P/. Хиймэл дагуулын технологиор солбицлыг нь тодорхойлсон цэгүүдийг Улсын байрлалын тулгуур сүлжээний /GPS/GLONASS/ цэг гэдэг. GPS-ийн Улсын сүлжээний цэгийг гравиметр, өндрийн, триангуляци, полигонометрийн цэгүүдтэй давхцуулж, солбицол, өндрийг тодорхойлсон бол уг цэгийн дэргэд тухайн сүлжээний /гравиметрийн эсвэл триангуляцийн/ цэгийн нэр, дугаарыг бичнэ.

6. /G106_P/. Газрын хүндийн хүчний хурдатгалын хэмжээг өндөр нарийвчлалтай хэмжиж тодорхойлсон бол гравиметрийн улсын сүлжээний Цэг гэдэг бөгөөд барилгын хонгил, шатны дор ихэвчлэн байна.

7. /G107_P/. Өндрийн сүлжээний Цэгийг суурь, энгийн (хөрсний), хадны, ханын ба түр репер гэж ангилдаг. Бүх төрлийн байр зүйн зурагт түр реперээс бусад өндрийн сүлжээний Цэгийг ижил Тэмдгээр дүрсэлж, шаардлагатай үед тайлбар бичиглэлийг (жишээ нь: "суурь.р.", "хөрс.р." г. м.) өгнө. Өндрийн сүлжээний Цэгийн дугаар ба өндрийг дараах зарчмаар бичнэ:

- хэрэв өндрийн сүлжээний Цэгийн толгой ба газрын өндрийн зөрөө 0.2 м ба түүнээс их бол хүртвэрт - Цэгийн өндрийг, хуваарьт - газрын өндрийг;

- дээрх өндрийн зөрөө 0.2 м-ээс бага бол хүртвэрт - Цэгтийн дугаар, хуваарьт - Цэгийн өндрийг тус тус бичнэ. Ханын репер, маркийн өндрийг тусгай шаардлагаар бичнэ.

8. /G108_P/. Хиймэл дагуулын технологиор байгуулсан С ангиллын сүлжээний цэг нь зураглалын сүлжээний цэг байдаг. Барилгын хана, өнцөгт байгаа зураглалын сүлжээний цэгүүдийг 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт оруулах ба 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар оруулна.

9. /G101_T/. Цэг тэмдэгтийн дугаар, өндрийг энэ давхаргад бичихдээ хуваарьт Цэгийн төвийн өндрийг, хүртвэрт Цэгийн дугаарыг бичнэ. Цэгийн төвийн өндрийг 0.01 м-ийн нарийвчлалтай бичнэ.

8.2 Авто зам

8.2.1 Авто замыг байр зүйн зурагт хурдны зам, засмал зам, сайжруулсан зам, хөрсөн зам, жим гэж хэд хэд ангилна дүрсэлнэ.

8.2.2 Нэг түвшинд байгаа хучилттай зам, хөрсөн замын огтлолцлыг байр зүйн зурагт үзүүлэхдээ тэдгээрийн Тэмдгийг зохих хэсэгт нь таслан үзүүлнэ. Замыг тодорхой суурин хүртэл эсвэл аль нэг авто замтай огтлолцох хүртэл үргэлжлүүлнэ.

8.2.3 Авто машины тодорхой хучилт бүхий зам ихэвчлэн тусгаарлах зурвастай, эсрэг урсгалтай байдаг. Иймээс замыг түүний өргөнийг харгалзан хаалт, ногоон байгууламж /бут, зүлэг, суулгац/ зэргийг байгаагаар нь дүрслэн үзүүлнэ. 1:500-аас 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт замын зорчих хэсэг, тусгаарлах зурвас, хашлага, замын тэмдэг, явган ба унадаг дугуйн зам, зам дагуух суваг, шуудууны хамт дүрсэлнэ. Овоолго шороо, далан, хонхорт байгаа замуудыг байр зүйн зурагт дүрслэхдээ бусад объектуудын Тэмдэг, онцлогийг харгалзана. Үүнд зөвхөн Тэмдгийг баримтлах бус хүснэгтэд үзүүлсэн нэмэлт жишээг баримтална.

8.2.4 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт хучилттай ба хучилтгүй авто замыг масштабын бус (өргөнөөр нь) Тэмдгээр дүрсэлнэ.

8.2.5 Замын хучилтын материалыг байр зүйн зурагт дор дурдсан товчилсон үсгээр тэмдэглэнэ:

А - асфальт, Б - бетон, Ч - чулуу, Х - хайрга. Эдгээр товчилсон үсгийг авто замын тэнхлэгийн дагуу хучилтыг харгалзан бичнэ.

8.2.6 Замын нийт өргөн, урсгалын өргөн 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт тоон утгаар (жишээ нь: 7.4 (4.2) А) өгөгдөнө.

8.2.7 Гол, мөрөн, нуур, далай, намгийг хөлдсөн үед явж болох замуудыг байр зүйн зурагт "өвл." гэсэн тайлбар бичиглэлтэй үзүүлнэ.

8.2.8 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

10-11. /A101_L - A102_L/. Хатуу хучилттай авто зам, (явган хүний зам, талбай, барилгын хаяавч) гудамжийг бүдэг саарал өнгөөр будна.

12. /A103_L/. Сайжруулсан авто зам гол замуудаас /хурдны, засмал/ бага өргөнтэй байх ба хөнгөн хучилттай (хайрга гэх мэт) байж болно.

13. /A104_L/. Хөрсөн замд хучилтгүй, элс, элсэн цөл, уул, ой, хөвчийн ердийн авто хөсгийн замууд багтана. Хөрсөн замыг хоёр төрлийн (тасалдалтай ба үргэлжилсэн) зэрэгцээ шугамаар үзүүлэх бөгөөд авто зам дүрслэх зарчмыг баримтална. Хэрэв 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт хөрсөн замыг хээрийн, ойн гэж ангилах бол "ойн.зам", "хээр.зам" гэсэн тайлбар бичнэ.

14. /A105_L/. Баригдаж байгаа авто машины замыг тасалдалтай зураасан Тэмдгээр үзүүлнэ. Баригдаж байгаа авто замын гүүр, замын бусад бүтээцийг байр зүйн зурагт ашиглагдаж буй байгууламж мэтээр оруулж, "барь." (баригдаж буй) гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

15. /A106_L/. Байр зүйн зурагт ердийн хөсгийн болон явган зөрөг жимийг адил Тэмдгээр үзүүлэх боловч ердийн хөсгийн зөрөгт тайлбар хийнэ. Ердийн хөсгийн зөрөг авто тээвэрт ашиглагддаггүй боловч говь цөлийн зарим бүсэд авто

тээвэрт ашиглаж болдог. Хүйтэн бүс (тайга) нутагт зарим зөргийг авто тээвэрт ашиглахаас гадна чаргаар тээвэр хийхэд ашигладаг.

16. /A107_L/. Авто замын тэнхлэгийн шугамыг замын зорчих хэсгийн тэнхлэгээр зурж холбогдох мэдээллүүдийг /замын дугаар, ангилал, хучилт, урсгал тусгаарлагчтай эсэх, урсгалын тоо/ хүснэгтэн мэдээнд оруулна.

17. /A108_A/. Авто замыг мэдээллийн сан үүсгэх зорилгоор талбайгаар зурна. Энэ давхарга нь битүү саарал өнгөтэй байна.

18. /A102_T/. Авто замын дугаар, хучилтын төрлийг байр зүйн зурагт 12-15 см зайтай тэмдэглэнэ. Замын үсгэн индексийг оруулахад дараах зэрэглэлийг баримтална. Үүнд:

"ОУЗ" – олон улсын зам,

"УЧЗ" - улсын чанартай зам,

"ОНЗ" – орон нутгийн зам.

8.3 Зам, түүний байгууламж

8.3.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

19. /A201_A/. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт явган хүн зорчих болон авто машин явах замыг тусад нь дүрсэлнэ. Гудамж, цэцэрлэг, оршуулгын газар дахь явган хүн зорчих замыг тэдгээрийн өргөнөөс хамааруулан масштабын эсвэл масштабын бус Тэмдгээр үзүүлнэ. Масштабын бус Тэмдгийг 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт 5 м-ээс бага, 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт 2 м-ээс бага өргөн замд хэрэглэнэ. Энэ масштабын бус Тэмдгийг 1 мм өргөн хос зэрэгцээ шугамаар үзүүлнэ.

Явган замыг бетондсон болон төрөл бүрийн хавтан, чулуугаар засаж тохижуулсан талбайн хамт дүрсэлнэ.

20. /A202_A/. Авто болон төмөр зам дээрх явган хүн зорчих гүүрийг масштабаар илэрхийлэгдэх бол шат, гүүрний эргэлт, мурийлтын хамт дүрсэлж "яв." гэсэн тайлбар бичиглэлийг хийнэ.

Газар дээрх агаарын замыг "дүүж." гэсэн тайлбар бичиглэлийн хамт байр зүйн зурагт оруулна. Агаарын зам нь тулгууртай бол тулгуурыг материалаар нь /C201_P/ ангилна.

21-23. /A203_A – A203_P/. Явган зорчих, авто ба төмөр зам тавигдсан газар доорх, уул нүхлэн тавьсан гарцыг (нүхэн гарц) байр зүйн зурагт тасархай шугамаар, газар дээрх ил хэсгийг үргэлжилсэн шугамаар үзүүлэх ба хонгилын орц, гарцыг мөн үзүүлнэ. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт орц, гарцын онцлог ба бодит байдлыг харгалзан зохих Тэмдгээр дүрсэлнэ.

24-26. /A204_A – A204_P/. Байр зүйн зурагт гүүрийг зориулалт, хэмжээ, хийц, материалаар нь ангилан дүрсэлнэ. Гүүрийн үндсэн хэсэг нь гулдан ба тулгуур болно. Гүүр нь зориулалтаараа төмөр замын, авто замын, явган замын гэж байна. 1 м хүртэлх урттай жижиг гүүрийг тэмдэглэхгүй бөгөөд харин 1-3 м урттай гүүрийг 1:500 болон 1:1 000, 2-7 м урттай гүүрийг 1:2 000, 5 м урттай гүүрийг 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт үзүүлнэ. Гүүрний гулдангийн материалыг бүх төрлийн масштабтай байр зүйн зурагт төмөр, төмөр бетон, чулуун, модон гэж ангилан тайлбар бичиглэл хийнэ. Жижиг гүүрний гулдангийн материал хийцийг /модон гүүрнээс бусад/ 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт "төм.", "чул." гэж, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт үсгээр "Т", "ТБ", "Ч", "М" гэж хураангуйлан үзүүлнэ.

Гүүрний тулгуурыг байр зүйн зурагт /C201_P/ Тэмдгээр үзүүлнэ. Мөн 1:500, 1:1 000-ны масштабын байр зүйн зурагт гүүрний хайс, шатны хашлагыг үзүүлнэ.

27. /A205_L/. Замын уулзвар, огцом эргэлт зэрэгт хамгаалалт, эсрэг хоёр урсгалын хооронд тусгаарлах зориулалтаар тавьсан төмөр, төмөр-бетон, модон материал бүхий хашлагыг 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт байрлалаар нь үзүүлж материалыг хүснэгтэн мэдээнд оруулна.

28. /A206_P/. Төмөр замын гарам, авто машины зогсоол, төлбөр авах цэгүүд ихэвчлэн хаалттай байдаг. Эдгээрийг зөвхөн 1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт байрлалаар нь дүрсэлнэ.

29-30. /A207_L – A208_P/. Самбар нь зар сурталчилгаа, зар мэдээ, хүндэт гэх мэт байж болно. Тэдгээрийг тусгайлсан байрлалтай (цэцэрлэг, талбай, зам дээр) бол байр зүйн зурагт дүрсэлнэ.

31. /A209_L/. Аймаг, сумын төв орох, түүнээс гарахад байрлуулсан төмөр-бетон, модон хийц бүхий нуман хаалга, авто зам, төмөр зам дээгүүр тавигдсан байнгын хаалгыг нуман хаалга гэж үзэн энэ давхаргад дүрсэлнэ.

32-33. /A210_A – A211_A/. Дугуйн, гүйлтийн замыг хил хязгаараар нь явган болон авто замтай уялдуулж үзүүлнэ.

34-35. /A212_A – A212_L/. Шуудуу, суваг, гол нь хоолойгоор дамжиж байгаа бол хоолойг тасархай хар шугамаар үзүүлэх ба түүний газар дээрх байрлалыг илтгэнэ. Хоолойн материалыг мэдээлэлд оруулж өгнө.

1м-ээс багагүй урттай хоолойн оролт, гаралтыг замын хоёр талын овоолготой уялдуулж үзүүлнэ. Байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар хоолойн материалыг түүний тоон тодорхойлолтын хамт зүүн талд бичнэ. Замын хучлага дор тавигдсан хоолойн тоон тодорхойлолтыг байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар тусгахад хоёр хувилбарыг баримтална:

- хучилтын үнэмлэхүй өндөр, хоолойн тоо түүний дотоод диаметр;
- хоолойн оролт, гаралтын өндөр ба хоолойн уртыг 0.1 м нарийвчлалтай тус тус тодорхойлж бичнэ.

36. /A213_P/ Төлбөр авах цэг нь авто зам ашигласны хураамж авах газар бөгөөд масштабын бус тэмдгээр дүрслэгдэнэ.

37-38. /A202_T, A205_T/. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт бүх төрлийн авто замын гүүрний нийт урт, замын өргөн, даац багтана. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт авто замын гүүрний тодорхойлолтод зөвхөн гүүрний даацыг өгөх ба бусад үзүүлэлтийг шууд хэмжилтээр тодорхойлно. Хэрэв даац 100 т-оос их бол бүх масштабын зурагт "даац 100т" гэж тэмдэглэнэ.

8.4 Замын элемент

8.4.1 Замын элементүүдийг сэдэвчилсэн болон мэдээллийн сан үүсгэх зориулалттай байр зүйн зурагт эсвэл ажлын даалгаварт тусгагдсан бол зураглана.

8.4.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

39-44. /A301_A - A306_P/. Явган хүний замын гарц, аюулгүйн бүс, авто зогсоолын хил зэргийг хил хязгаараар нь хүрээлэн үзүүлнэ.

Автобус, троллейбус, таксины зогсоолын Тэмдгийг зогсоол бүхий газарт тавина. Хэрэв зогсоол нь сүүдрэвчтэй, замыг тусгайлан өргөжүүлсэн зэргээр тоноглогдсон бол бодит байдлаар нь зураглана.

45-48. /A307_P – A310_P/. Зам түүний элементэд түүний дагуу байрлуулсан км-ын тэмдэг, гэрлэн дохио, троллейбусны шон, замын /заах, хориглох, анхааруулах/ тэмдгүүд зэрэг багтана. Эдгээр Тэмдгүүдийг тусгайлан сэдэвчилсэн /авто замын/ зураг зохиоход үзүүлнэ.

1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт дээр дурдсан объектуудыг үзүүлэхдээ сонголт хийж оруулах ба аль болох тохиромжтойгоор байрлуулна.

49-50. /A311_L - A312_P/. Авто замын аваар осол, аюулгүй байдал, авто замын зорчих хөдөлгөөний дүрэм журмыг хэрэгжүүлэх үүднээс байгуулсан хурд сааруулагч, хурд хэмжигчийг байрлал, хэмжээгээр нь эдгээр давхаргуудад зурж өгнө.

51. /A313_L/. Авто замын тусгаарлагч цагаан шугамыг замын зорчих хэсэгт тавигдсан байдлаар нь зурагт оруулна.

8.5 Төмөр зам

8.5.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

52. /A401_L/. Бүх төрлийн өргөн ба нарийн төмөр замыг байр зүйн зурагт дүрсэлнэ. 1520 мм өргөнтэй зам-төмөртэй бол өргөн, 600-1067 мм өргөнтэй зам-төмөртэй бол нарийн төмөр зам гэнэ. Бүх төрлийн төмөр замыг тэнхлэгээр нь зураглаж байр зүйн зурагт дүрсэлнэ. Мөрийг дүрслэхэд зарим тохиолдолд Тэмдгийн шугамын өргөнийг 0.7-оос 0.5 мм хүртэл багасгаж болно. Ашиглагддаггүй төмөр замыг ажиллагаатай төмөр замаар зурж "аж-гүй." гэсэн тайлбар бичиглэл хийнэ. Нарийн төмөр замыг байр зүйн зурагт "нарийн." гэсэн тайлбар бичиглэлтэй дүрсэлнэ. Хэрэв зам шигүү барилга байгууламж дундуур гарсан бол зөвхөн гол замыг дүрсэлнэ.

53. /A402_L/. Барьж буй өргөн ба нарийн төмөр замыг тэнхлэгээр нь байр зүйн зурагт тасалдалтай шулуунаар зурна.

54. /A403_L/. Төмөр замын тэнхлэгийн шугамыг төмөр замын тэнхлэг дагуу зурна. Төмөр замын өртөө, зөрлөг бүхий хэсэгт нийт замын гол тэнхлэгээр оруулна.

55. /A404_P/. Төмөр замыг шилжүүлэх сумыг зөвхөн 1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар дүрсэлнэ.

56. /A405_A/. Төмөр замын зорчигчдын болон ачаа тээшний тавцан ил ба дээвэртэй байх бөгөөд тэдгээрийн бүтээц, хучилтын материалыг байр зүйн зурагт үзүүлнэ. Цардмал буюу төмөр бетон хавтангаар хучсан тавцангийн дүрслэлийг бүдэг саарал өнгөөр будна. 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт өндөр тавцангуудын бүх шат, уулзваруудыг дүрслэн тавцангийн үзүүрийн өндрийг бичнэ. Зам хоорондох тавцанг 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт сонгон дүрсэлж болно. Төмөр замын ачаа тээшний тавцанд "ачаа." гэсэн тайлбар бичиглэл хийнэ. Өндөр тавцангуудаас ачаа буулгах талбай болон агуулах, барилгад шууд залгагдсан тавцангуудыг (2-3 м өргөн байж болох) ялгаж дүрсэлнэ.

57. /A406_P/. Төмөр замын галт тэрэг оруулах гэрлэн дохиолуурыг ихэвчлэн замын баруун талд байрлуулдаг. Дохиолуурын Тэмдгийг төмөр замын дүрсийн шугамтай зэрэгцээ (параллель) зурна. Харин 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зургийн ачаалал ихэдвэл сонгон (захын дохиолуурыг заавал оруулна) дүрсэлнэ.

58. /A407_P/. Төмөр зам дагуух төрөл бүрийн анхааруулгын самбарыг байр зүйн зурагт нэг төрлийн Тэмдгээр байрлалаар нь дүрсэлнэ.

59. /A408_L/. Зам төмрийн төгсгөл-мухар хэсгийг байгаа байдлаар нь байр зүйн зурагт оруулна.

60. /A401_T/ Төмөр замын өргөн, нарийн, ажилладаггүй гэх зэрэг тайлбар бичиглэлийг масштаб тус бүрт тохирсон хэмжээгээр уг давхаргад бичнэ.

8.6 Барилга, байгууламж

8.6.1 Барилга, байгууламж гэдэгт - бага оврын байшин, хөнгөн хийцийн дээвэртэй барилга, өөрийн хэмжээ, зориулалтаараа орон сууц, албан ба үйлдвэрийн зориулалттай барилга багтана.

8.6.2 Том масштабын байр зүйн зурагт барилга, байгууламжийг дотор нь: орон сууцны, орон сууцны бус гэж ангилж зурна.

8.6.3 Саравчит тагт - гэж ихэвчлэн гурван талаасаа (эсвэл шиллэсэн) хаалттай бүтээцийг хамааруулна. Байр зүйн зурагт түүнийг хэмжээнээс нь хамааруулан барилгын дүрсэнд нь оролцуулж зурна.

8.6.4 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт тагтыг нэмэлт шаардлагаар дүрслэх, 1:5 000-ны зурагт үзүүлэхгүй.

8.6.5 Барилгыг консалттай хэсгийг байр зүйн зурагт ялгаж зурна.

8.6.6 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

61-63. /B101_A – B103_P/. Барилгыг байр зүйн зурагт байгаа хэлбэр хэмжээгээр нь оруулна. Масштабд илэрхийлэгдэх барилгыг түүний сууриар оруулах бөгөөд өнцөг, булан тохой зэргийг байр зүйн зургийн масштабд 0.5 мм ба түүнээс том бол дүрсэлнэ. Агаарын зураглалын аргаар байр зүйн зураг хийж байгаа тохиолдолд барилгыг дээврээр нь зурагт оруулна.

Хоорондоо завсаргүй нийлүүлж барьсан барилгыг тус бүр салгаж зурна.

Орон сууцны бус нийтийн зориулалттай барилга, байгууламжид 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт "захирг.", "зас.газ.", "эмн.", "дэлг.", "кинотеатр", "үйлд." гэсэн тайлбар бичиглэлийг (захиргаа, засварын газар, эмнэлэг, дэлгүүр, кино театр, үйлдвэр гэх мэт) холбогдох Тэмдгийн /B201_P-B611_P/ хамт өгнө. Барилга нь орон сууц болон нийтийн зориулалтаар ашиглагдах тул тухайн үйл ажиллагааны чиглэлийн Тэмдгийг барилгын дүрсийн дотор баруун хойд хэсэгт тавьж өгнө.

Барилгын давхрын тоонд барилгын хонгил, дээврийн сүүдрэвч зэргийг оруулж тооцохгүй. 1:500 - 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт янз бүрийн давхартай барилгын давхар бүрийг ялгаж зурна. 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт барилгын зориулалт, давхар зэргийг барилгын дүрсийн дотор талд багтаах боломжгүй тохиолдолд түүний гадна талд барилгын урт талын дагууд (параллель) бичнэ.

Барилгын дээвэр дээр чиг баримжаа болох цамхаг төрлийн зүйл байвал тухайн барилгын дүрсэн дотор уг биетийг байрлалаар нь /Тайлбар 67/ оруулна. Том хэмжээний объект байвал хүрээ өгч, тайлбар бичиглэл хийнэ.

Байр зүйн зурагт барилгын дугаарыг ажлын даалгаварт заасан тохиолдолд үзүүлэх бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд: 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт бүх дүрслэгдсэн суурин газрын барилгуудын дугаарыг, 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт хорооллын өнцөг бүрт байгаа барилгуудын дугаарыг, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт шаардлагатай үед үзүүлнэ. Барилгын дугаарыг уг дүрсийн дотор баруун доод өнцөгт эсвэл гудамж уруу харсан хэсэгт бичнэ.

64. /B104_A/. Барилгын суурь цутгагдсан, барьж буй барилгад "барь." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Хэрэв барилгын дээвэр нь хучигдсан бол барилгыг баригдсан барилгаар зурж 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт "барь." гэсэн тайлбар бичиглэлтэй дүрсэлнэ.

65-66. /B105_P - B105_A/. Барилга нь бүхэлдээ буюу түүний хэсэг нь нурсан бол "нур." гэсэн тайлбар бичиглэлтэй зурна. Засвар, өөрчлөлт хийж буй барилгад ийм тайлбар хэрэглэхгүй. Хэрэв 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт нурсан буюу хагас нурсан барилгын талбай 1 см.кв ба түүнээс их бол уг барилгын хүрээг үзүүлж "нур." гэсэн тайлбар бичиглэлийг бичнэ.

67. /B106_P/. Цамхаг хэлбэрийн барилгыг байр зүйн зурагт уг барилга нь дугуй, олон өнцөгт, дөрвөлжин зэрэг ямар дүрстэй байгаагаар нь дүрсэлж дотор талд нь Тэмдэг тавих буюу "цамхаг" гэсэн тайлбар бичиглэлийг хураангуйлан

бичнэ. Үйлдвэрийн газрын усан хангамжийн эргэлтийн системийн усыг хөргөх төхөөрөмж хэлбэрийн цамхагт "хөр.цамх.", эрт үеийн харуул хамгаалалт, ажиглалтын цамхагт "түүх.цамх." гэсэн тайлбар бичнэ.

1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт цамхгийн материалыг "Т." буюу "Б." үсгээр тэмдэглэнэ. (Т-төмөр, Б-бусад материал).

Хөнгөн хийцийн цамхгийг масштабын бус Тэмдгээр үзүүлнэ.

68. /B107_A/. Авто машины гарааш гэх мэт бага оврын барилга байгууламжийг ихэвчлэн 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт тайлбар бичиглэлийн хамт дүрсэлнэ. Хэд хэдэн гараашийг нийлүүлж барьсан бол эдгээрийг зааглаж дүрслэн бүтээц материалыг (тоосго, чулуу гэх мэт) мэдээлэлд оруулна.

69-70. /B108_P - B108_A/. Үр соёолуулах байр, хүлэмжийг байр зүйн зурагт орон сууцны бус барилгаар (1:2 000-1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт тусгай Тэмдгээр) дүрсэлж, холбогдох тайлбарыг бичнэ.

71-72. /B109_P - B109_A/. Зоорийг бүх масштабын байр зүйн зурагт дүрслэх боловч 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт түүний хэмжээг харгалзан масштабын бус Тэмдгээр зурна. 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт зоорийн талбай 4 мм.кв ба түүнээс том тохиолдолд болон хот суурины барилгажсан хэсгийн гадна талд буй зоорийг дүрсэлнэ. Зоорийн Тэмдгийн дэргэдэх тайлбар бичиглэлийг түүний дүрсийн урт, тэнхлэгийн дагуу бичнэ. Бага оврын хэд хэдэн зоорийг нийлүүлж, зурвас байдлаар байрлуулсан бол нэг тэмдгээр дүрсэлж "зоорь" гэсэн тайлбар бичнэ. Газар дээрээ томоохон ногоо хадгалах байраар ашиглаж байгаа бол зоорийн Тэмдэг хэрэглэх боловч "ног.зоорь" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

73-74. /B110_P - B110_A/. Том масштабын байр зүйн зурагт сүүдрэвчийг дотор нь байшин хоорондох, шонтой, саравч-сүүдрэвч гэх мэт ангилна.

Саравч-сүүдрэвчийг 1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт дүрсэлнэ. 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт сүүдрэвчийн талбай нь 4 мм.кв-ээс багагүй байх тохиолдолд үзүүлнэ. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт сүүдрэвчийг масштабын бус Тэмдгийг шаардлагатай бол оруулна.

Төмөр замын ачаа буулгах, хүн тээвэрлэх тавцангийн болон шатахуун түгээгүүрийн дээвэртэй сүүдрэвчийг тулгуурын хамт /C201_P/ 1:500, 1:1 000-ны байр зүйн зурагт үзүүлнэ.

75-76. /B111_P - B111_L/. Суурин газрын шинж төрх, захиалагчийн шаардлагыг харгалзан бүх масштабын байр зүйн зурагт барилгын үүдэн шат, орцыг барилгын сууриас 0.5 мм ба түүнээс илүү гарсан бол дүрсэлнэ. Энэ ангилалд үүдний шат, газар доорх барилгын хэсэгт нэвтрэх ил ба хаалттай орц хамаарна.

Зургийн масштабд дүрслэгдэхгүй үүдэн шат ба газар доорх барилгын хэсэгт орох орцыг өөрийн хэмжээ, овроороо томоохон барилгад /засаг захиргаа, уран барилга гэх мэт/ 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт зөвхөн барилгын нүүр талын орц, гарцыг үзүүлнэ.

Хоёрдугаар давхарт гарах замыг (зарим зочид буудал, гарааш, агуулахад байдаг) 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт замын доод үзүүрийн газрын түвшин, хоёр давхар барилгын ханын дэргэдэх түвшингийн өндрийн хамт дүрсэлнэ.

Уул, овоолго шороо, далан, гүүрний шатыг тэдгээрийн газар дээрх байрлал, чиглэлийг харгалзан 1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт шатны гишгүүр, талбай бүрийг нарийвчлан оруулна.

77. /B112_A/. Орчин үеийн барилгын суурийг тойруулсан цардмал буюу бетон хучилтыг хаяавч гэх бөгөөд 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт бүх хаяавчийг, 1:2 000-ны зурагт газар дээрээ 1.2 м ба түүнээс их өргөнтэй буюу

тухайн газар орчинд уг хаяавч нь явган зам болох тохиолдолд үзүүлнэ. 1:5 000-ны масштабтай зурагт дүрслэхгүй. Хаяавчийг агаарын зураглалын аргаар байр зүйн зураг хийж буй тохиолдолд үзүүлэхгүй.

78-79. /B113_A-B113_P /. Нэг давхартаа баганатай буюу барилгын хэсгийг 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт ялгаж дүрсэлнэ. Барилгын баганыг үзүүлэхдээ тухайн масштабд бүх баганыг дүрслэх боломжгүй бол тэдгээрийг сонгож үзүүлэх бөгөөд захын хоёр баганыг бодит байрлалаар нь бусдыг 5-6 мм бүрт зурна. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт баганатай барилгыг ердийн байдлаар дүрслэн үзүүлнэ.

80-81. /B114_A - B114_L/. Нуман хаалган гарцын Тэмдгийг нэг байшингаас нөгөө байшинд, гудамж талбай хооронд орох гарц замыг тэмдэглэхэд хэрэглэнэ. Ийм Тэмдгийг барилга хоорондын газраас хөндий хэсгийг (хүзүүвч) дүрслэхэд мөн хэрэглэнэ.

82. /B115_L/. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт түймрийн шатыг дүрслэхдээ уг шат нь газар дээр бэхлэгдсэн эсвэл байшингийн довжоонд тулгууртай тохиолдолд үзүүлнэ.

83. /B116_P/. Засаг захиргаа, томоохон соёл, боловсрол, үйлчилгээний газрын барилгын үүдэнд байх туг далбаа мандуулах зориулалт бүхий шонг байрлалаар нь байр зүйн зурагт оруулна.

84. /B117_A/. Тусгай нэгдсэн хашаа, хамгаалалттай, нэг загвараар буюу нэг зураг төслөөр баригдсан тодорхой нэр бүхий барилгажсан хэсгийг хороолол, хотхон гэж ойлгоно. Суурин газрын барилгажсан хэсгийг шигүү, сийрэг барилгажилттай байдлаар нь ялгаж 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт, шаардлагатай бол 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт хэрэглэнэ.

85. /B118_A/. Байр зүйн зурагт барилгын тулгуургүй хэсэг /консалт/, газар доорх барилгыг тасархай зураасаар дүрсэлнэ. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт энэ Тэмдгийг шаардлагатай буюу тухайн масштабд илэрхийлэгдэх тохиолдолд хэрэглэнэ.

86. /B119_P/. Дөрвөн цагийн улиралд нүүдэллэн бууж гэр барихад зориулан цутгасан бетон суурь, төмөр-бетоноор цутгасан гэрийг байр зүйн зурагт энэ Тэмдгээр дүрсэлнэ.

87. /B120_A/. Газар доорх байгууламжийн тухайн масштабд илэрхийлэгдэх агааржуулагчийг байрлал, хэлбэр хэмжээгээр нь байр зүйн зурагт оруулна.

88. /B101_T/. 1:500 - 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт барилгын бүтээц материалыг үсгээр тэмдэглэнэ: "Т", "ЦУ", "У", "СЭ", "СҮ", "БУ" (тоосго, цутгамал, угсармал, сэндвич, сүрэл, бусад гэх мэт). Нэмэлт шаардлагаар модоор хийгдсэн барилгын материалыг бичнэ. Харин 2 болон түүнээс дээш давхартай модон барилгын материалыг тэмдэглэнэ. Барилгын нэгдүгээр давхар нь галд тэсвэртэй материалаар, хоёрдугаар давхар нь эсвэл дээвэр нь галд тэсвэргүй материалаар хийгдсэн байх буюу бүх барилга модоор хийгдсэн, өнгөлгөө нь галд тэсвэртэй материалаар (тоосго гэх мэт) өнгөлөгдсөн байж болно. Ийм барилгыг холимог материалтай барилга гэж "ХМ" гэсэн үсгээр тэмдэглэнэ.

89. /B102_T/. Барьж буй, нурсан объект, зоорь, хүлэмж, Засаг даргын тамгын газар, эмнэлэг, сургууль гэх мэт барилга байгууламжийн тайлбар бичиглэлийг тухайн барилгын дотор талд төв хэсэгт тухайн барилгын урт талын дагуу бичнэ.

90. /B100_T/. Барилга, байшингийн албан ёсны дугаарыг энэ давхаргад бичнэ. Барилгажсан хэсгийн хаягийг бичихдээ Тайлбар 61-63 баримтална.

8.7 Олон нийтийн байгууллага

8.7.1 Орон сууцны буюу орон сууцны бус барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулж буй засаг захиргааны байгууллагуудыг байр зүйн зурагт эдгээр Тэмдгээр дүрсэлж өгнө.

8.7.2 Тэмдгийг тухайн барилгын дотор талд баруун хойд буланд байрлуулан тухайн байгууллагын нэрийг хүснэгтэн мэдээлэлд оруулна.

8.7.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

91-94. /B201_P – B204_P/. Нийслэл, хот-аймаг, сум-дүүрэг, баг-хороонд тухайн засаг захиргааны төв, нутгийн удирдлагын ордныг хамааруулж ойлгоно.

95. /B205_P/. Төрийн байгууллагад засгийн газрын болон нийслэлийн төр захиргааны байгууллагууд хамаарагдана. /яам, агентлаг, ШУА-ийн харьяа хүрээлэн тэдгээрийн салбар/ Хууль сахиулах байгууллагууд үүнд хамаарахгүй.

96. /B206_P/. Бүх төрлийн шинжилгээ, эмчилгээ оношилгоо хийх, хэвтэж эмчилгээ хийлгэх боломж бүхий эмнэлгийн газрыг эрүүл мэндийн төв гэсэн ойлголтод хамааруулна.

97-98. /B207_P – B208_P/. Бүх шатны шүүх, прокурорын байгууллагуудын барилга дээр зохих Тэмдгийг тавьж өгнө.

99-100. /B209_P – B210_P/. Цагдаагийн газарт нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллага, цагдаагийн хэлтэст хорооны цагдаагийн хэлтэс, цагдаагийн постууд хамаарагдана.

101-105. /B211_P – B215_P/. Хорих газар, гал команд, татвар, гааль, шуудангийн газар болон тэдгээрийн салбаруудад холбогдох Тэмдгийг тавьж өгнө.

106. /B216_P/. Цаг уурын станцыг гаднах хашаа хамгаалалтын хязгаараар үзүүлж "ус цаг уур.ст." гэсэн тайлбартай дүрсэлнэ.

107. /B217_P/. Монголын цахилгаан холбоо ТӨХК болон үүрэн холбооны операторуудын салбарууд хамаарагдана.

108. /B218_P/. Нийгмийн халамжийн төв гэдэгт нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, өндөр настан асран хамгаалах байгууллага, тэдгээрийн аймаг, сум, дүүрэг, хорооны салбарууд хамаарагдана.

109. /B219_P/. Хүүхдийн төв гэдэг нь хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн болон олон улсын байгууллага болно.

8.8 Соёл боловсролын байгууллага

8.8.1 Орон сууцны буюу орон сууцны бус барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулж буй соёл боловсролын байгууллагуудыг байр зүйн зурагт эдгээр Тэмдгээр дүрсэлнэ. Тэмдгийг тухайн барилгын дотор талд баруун хойд буланд байрлуулан тухайн байгууллагын нэрийг хүснэгтэн мэдээлэлд оруулж өгнө.

8.8.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

110-115. /B301_P – B306_P/. Сургууль, цэцэрлэг, номын сан, төрөл бүрийн сургалт үйлчилгээний газар /курс, дамжаа/, оюутан, сурагчдын дотуур байр, биеийн тамирын заалны барилгад эдгээр Тэмдэг тавигдана.

Төрөл бүрийн нарийн мэргэжлийн болон гадаад хэлний богино хугацааны сургалт явуулдаг газар нь сургалтын төв болно.

116. /B307_P/. Бурхан шашны үйлсэд зориулан барьсан барилгыг (сүм, дуган, хийд гэх мэт) байр зүйн зурагт дүрслэхдээ уг барилга тухайн үедээ хэрэглэгдэж байгаа эсэхийг үл харгалзан үзүүлнэ.

Буддын шашны сүм, дуганы Тэмдгийг эдгээр барилгын хамгийн өндөр хэсгийн байршил дээр үзүүлнэ.

117. /B308_P/. Христосын шашны загалмайн Тэмдгийг уг дуганы бөмбөгөр оройн байршил дээр эсвэл хэд хэдэн бөмбөгөр оройтой бол хамгийн өндөр орой

дээр байрлуулна. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт бөмбөгөр оройг дүрслэхгүй.

118-119. /B309_P - B310_P/. Лалын шашин, католик шашны сүмийн гол барилгын бөмбөгөр оройг сүмийн цамхаг гэж түүнийг суурийн хэмжээгээр зурж "ганжир" гэсэн тайлбар бичиглэлтэй үзүүлнэ. Масштабт дүрслэгдэхгүй бол 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт тогтоосон Тэмдгээр нь зурна.

120. /B311_P/. Шашны үйлсэд зориулсан масштабт дүрслэгдэхгүй суваргыг (1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт байж болох) Тэмдгээр зурна.

121-125. /B312_P – B316_P/. Музей, уран зургийн галерей, соёлын төв, телевиз, радио нэвтрүүлгийн байгууллагуудыг эдгээр Тэмдгээр тэмдэглэнэ.

126-127. /B317_P – B318_P/. Сонины газар гэж сонин сэтгүүл борлуулах газар, сэтгүүлийн газарт хэвлэн үйлдвэрлэх газар болно.

128. /B319_P/. Театр гэдэг нь үзвэр үйлчилгээний газар юм.

129. /B320_P/. Хүүхдийн халамжийн төв гэж хүүхэд хүмүүжүүлэх, сурч боловсрох орчин бүхий хүүхдийн төлөө байгууллага болно. Хүүхдийн халамжийн төвд өдөр өнжүүлэх газрыг хамааруулж ойлгоно.

130. /B321_P/. Баримал, хөшөөг (чулуу ба бусад материал орсон) масштабын бус Тэмдгээр дүрсэлж, "баримал", "хөшөө" гэсэн үгийг хураангуйлан бичнэ. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт томоохон баримлыг түүний суурийн хэмжээний дагуу дүрсэлж дотор нь Тэмдгийг тавина.

Хөшөө, цогцолбор нь /дайнд оролцогчдын булш бунхан гэх мэт/ утгын хувьд ойролцоо боловч цогцолбор нь амьд байгаа хүмүүст зориулан барьсан байж болно. Мөн цогцолбор нь хөшөө - уран барилгын нэгэн цогц бүтээл байдгаараа онцлог юм. Энэ тохиолдолд цогцолборын бүх барилга байгууламжийг түүний хэмжээгээр нь тухайн масштабын байр зүйн зурагт дүрслэх бөгөөд дүрсийн төвд зохих Тэмдгийг тавина.

131. /B322_P/. Мөнхийн галыг байр зүйн зурагт улаан өнгөөр_ялгаж (ихэвчлэн 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт) үзүүлнэ.

8.9 Үйлчилгээний байгууллага

8.9.1 Орон сууцны буюу орон сууцны бус барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудыг байр зүйн зурагт эдгээр Тэмдгээр дүрсэлж өгнө. Тэмдгийг тухайн барилгын дотор талд баруун хойт буланд байрлуулан тухайн байгууллагын нэрийг хүснэгтэн мэдээлэлд оруулж өгнө.

8.9.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

132. /B401_P/. Зочид буудал гэж зочид хүлээн авах хэсэг, ресторан, авто машин зогсох гарааш талбайтай томоохон хэмжээний газар байна.

Зочид буудалд олон улсын зочид буудлын шаардлага, стандартыг хангасан арга хэмжээ явуулах өрөө тасалгаатай өндөр зэрэглэлийн зочид буудлууд мөн хамаарагдана.

133. /B402_P/. Дэн буудал гэдэгт суурины зах эсвэл хөдөө орон нутгийн зам дагуу байрлах жижиг хэмжээний хоноглох байртай /гэр, цайны газар бүхий/ газар юм. Үүнд багахан хэмжээний цөөн хүн хүлээн авах хүчин чадал бүхий /аймаг, сумын төв доторх/ буудлыг мөн хамааруулж ойлгоно.

134. /B403_P/. Өөрийн эзэмшил талбайтай, гал тогоо, хоолны заалны зориулалттай барилга байгууламжтай, амрагчид байрлуулах гэр, байшин бүхий уулын аманд улирлын чанартай болон байнгын үйл ажиллагаа явуулдаг, хашаа хамгаалалт бүхий үйлчилгээний газрыг уг ангилалд хамааруулж зурагт үзүүлнэ.

135. /B404_P/. Нийтийн халуун усны газар, саун /ууранд сууж усанд орох зориулалт бүхий газар/-ыг энэ Тэмдгээр үзүүлнэ.

136-143. /B405_P – B412_P/. Банк, даатгал, өртөө, нисэх буудал, засварын газар, шатахуун түгээгүүр, угаалгын газар зэрэг нь байр зүйн зурагт зохих Тэмдгээр тэмдэглэгдэнэ. Эдгээр үйлчилгээний байгууллагууд өөрийн байртай бол зохих тайлбар бичиглэл хийнэ. /"Хаан банк", "Ард даатгал" гэх мэт/

Шатахуун түгээх станцын барилга, түгээх хэсэг, шатахуун агуулах сав /C112_A/-ыг тус тусын давхаргад зурж "ШТС" гэсэн тайлбар бичиглэл хийнэ.

144-145. /B413_P – B414_P/. Эмнэлэг гэж тусгай нэг чиглэлээр төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг буюу шинжилгээ, оношилгоо хийх төвүүд орно. Энэ Тэмдгээр өрхийн эмнэлгүүдийг мөн тэмдэглэнэ. Эмийн санд эм, тариагаар жорын дагуу үйлчилгээ үзүүлдэг газар орно.

8.10 Үйлдвэр худалдаа

8.10.1 Орон сууцны бус барилга, байгууламжаар зурагдсан, хашаа хамгаалалт бүхий үйлдвэр худалдааны байгууллагуудыг байр зүйн зурагт эдгээр Тэмдгээр дүрсэлнэ. Тэмдгийг тухайн барилга, хашаа, хайсны дотор талд баруун хойд буланд байрлуулан тухайн байгууллагын нэрийг хүснэгтэн мэдээлэлд оруулж өгнө.

8.10.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

146. /B501_P/. Үйлдвэр, цахилгаан станц зэрэг үйлдвэрийн үйлдвэрлэлийн-байр гэдэгт цех, машин тоног төхөөрөмжийн байр, бэлэн бүтээгдэхүүний агуулах зэргийг хамруулна. Эдгээрийг болон үйлдвэрийн талбай доторх янз бүрийн байгууламжийг түүний гаднах овор хэмжээгээр нь дүрсэлнэ.

147. /B502_P/. Цахилгаан станц гэдэг нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн газар юм.

148. /B503_P/. Дэд станц хоёр янз байдаг: хаалттай, ил. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт масштабд дүрслэгдэхгүй бол зөвхөн Тэмдэг тавина. Ил дэд станцад хашааны хүрээг оруулж, дотор талын байгууламжийг дүрслэхгүй. Дэд станцын Тэмдгийн дэргэд "дэд.ст" гэсэн тайлбар бичиглэл бичнэ.

Дэд станцын тусгай тавцан нь масштабд дүрслэгдэх (1:500, 1:1 000-ны) бол түүнийг хэмжээгээр нь оруулна. Дэд станцын тавцангийн тулгуурыг бүтээц материалаар нь /C201_P/ дүрсэлнэ.

149. /B504_P/. Хувьсгуурын (трансформатор) байрыг 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт дүрсэлнэ. 1:2 000, 1:5 000-ны байр зүйн зурагт хувьсгуурын (масштабд дүрслэгдэх) барилгыг дүрсэлж Тэмдгийг барилгын дүрсийн дотор буюу гадна талд бичнэ. Масштабд дүрслэгдэхгүй байрыг зөвхөн Тэмдгээр нь зурна.

150. /B505_P/. Хүнс болон барааны бүх төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулах худалдааны төвийг Их дэлгүүрт тооцно.

151. /B506_P/. Нэг төрлийн бараа бүтээгдэхүүн буюу хүнс, барааны өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг зарж борлуулах 8 нэрийн худалдааны газрыг дэлгүүр гэсэн ангилалд хамааруулна.

152-153. /B507_A - B507_P/. Нэгдсэн хашаатай буюу төвлөрсөн нэг газарт /задгай талбайд/ худалдаа хийх газар нь худалдааны зах болно. Худалдааны захын Тэмдгийг сэдэвчилсэн болон мэдээллийн сан үүсгэх тохиолдолд ихэвчлэн хэрэглэнэ. Худалдааны захын хилийн баруун хойд буланд Тэмдгийг тавьж өгнө.

154-155. /B508_P – B509_P/. Үйлдвэрийн болон мал аж ахуйн хаягдал цэвэрлэх байгууламж нь эдгээр давхаргад тэмдэглэгдэнэ.

156. /B510_P/. Ахуйн бохирдол цэвэрлэх байгууламжид уг Тэмдэг хэрэглэгдэнэ.

157-158. /B511_P – B512_A/. Ус шавхах түгээх байгууламжийн хилийг сэдэвчилсэн болон мэдээллийн сан үүсгэх тохиолдолд зурах бөгөөд Тэмдгийг байгууламжийн хил дотор /байшин, хашааны/ тэмдэглэж өгнө.

8.11 Амралт, тоглоом

8.11.1 Орон сууцны буюу орон сууцны бус барилга, байгууламж, тусгай талбайд амралт, тоглоомын зориулалттай үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг байр зүйн зурагт эдгээр Тэмдгээр дүрсэлнэ. Тэмдгийг тухайн барилга, хашаа, хайс, талбайн баруун хойд буланд байрлуулна.

8.11.2 Байнга ашиглагддаг цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн, морин тойруулга, цанын харайлттай зам зэрэг спортын объектыг тэдгээрийн гаднах хэмжээ, доторх бүтээцийн хамт, тайлбар бичиглэлтэй хослуулан дүрсэлнэ.

8.11.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

159. /B601_P/. Хашаа хайстай, хайсгүй хүүхэд тоглох тоног төхөөрөмж /гулсуур, савлуур гэх мэт/ бүхий талбайг хүүхдийн тоглоомын талбай гэнэ. Хүүхдийн тоглоомын талбайн хил хязгаар дотор энэ Тэмдгийг тавина.

160-161. /B602_P – B603_A/. Спортын талбай, морин тойруулгын (үзэгчдийн индэргүй) хашаа хамгаалалтыг холбогдох Тэмдгээр хүрээлэн зурж, спортын талбай, цэнгэлдэх хүрээлэн, морин тойруулга гэсэн нэрийг *"спорт.талб."*, *"цэнг.хүр."*, *"морин.тойр."* гэж хураангуйлан бичнэ.

Эдгээр объект нь үзэгчдийн индэртэй бол 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт үзэгчдийн байрыг сектороор нь хуваарилж дүрсэлнэ.

162. /B604_P/. Алжаал тайлах зориулалт бүхий халуун рашаан бүхий барилгад Тэмдгийг тавина.

163. /B605_A/. Амарч зугаалах зориулалтаар хашаа хамгаалалт, хайс бүхий мод, бут, усан оргилуур, зам талбай, гэрэлтүүлгээр тохижуулсан газрыг цэцэрлэгт хүрээлэнгээр дүрсэлнэ.

164. /B606_P/. Гол, нуурын загасчлах тохиромжтой газарт энэ Тэмдгийг тавина.

165-168. /B607_P – B610_P/ Амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд зориулан байгуулсан газруудыг /гольф, газрын теннис, цанын талбай, усан бассейн/ эдгээр Тэмдгээр үзүүлнэ.

169. /B611_P/. Эргийн зурвас дагуу байгуулсан наранд шарах зориулалт бүхий газрыг байр зүйн зурагт энэ Тэмдгээр үзүүлнэ. Усанд орох газрын ил хөрс /элс, шавар гэх мэт/ эсвэл өвс ургамлын байдлыг харгалзан наранд шарах газрыг тодорхойлно.

8.12 Хашаа, хамгаалалт

8.12.1 Байр зүйн зурагт дүрслэгдэх хашаа хамгаалалтыг тоосго, чулуу, төмөр-бетон, төмөр, блок; олон төрлийн суурь ба тулгуур бүхий модон, төмөр хашаа; янз бүрийн хэлбэрийн төмөр утсан хаалт; хайс гэж ялгана.

8.12.2 Хашаа, хамгаалалтын эргэлт, догол бүрийг гадна талаас нь зураглах бөгөөд Тэмдгийн чиглэл, хашааны дотор тал руу чиглэсэн байна. 1м болон түүнээс дээш өндөртэйг хашаа, 1м-ээс доош өндөртэй болон сараалжин хэлбэрийн хашааг хайс гэж үзнэ. Хашаа, хайс нь тоосго, бетон, блокон суурь эсвэл баганатай байж болох бөгөөд үндсэн хэсэг нь ямар материалаар хийгдсэнээр байр зүйн зурагт үзүүлнэ.

8.12.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

170. /B701_L/. Модоор баригдсан 1м болон түүнээс дээш өндөр бүхий хашааг энэ Тэмдгээр үзүүлнэ.

171-172. /B702_L – B703_L/. Тоосго, чулуу, төмөр бетон, блокоор хийгдсэн хашаа хамгаалалтыг эдгээр давхаргад дүрсэлнэ.

173. /B704_L/. Торон, төмөр утсан хашаа гэж төмөр утсыг нугалж торлосон, янз бүрийн хэлбэртэй хашааг хэлнэ.

174. /B705_L/. 1м-ээс намхан төмөр, мод, тоосго, блок, бургас зэргээр барьсан сараалжин хашаа нь хайс болно.

175-176. /B706_L – B706_P/. Мал хаших зориулалтаар барьсан хашаа, хамгаалалтыг үүнд хамааруулж ойлгоно.

177. /B707_L/. 1:500, 1:1 000-ны масштабтай зурагт хашааны хаалгыг үзүүлнэ. Харин 1:2 000-1:5 000-ны масштабтай зурагт тухайн масштабд илэрхийлэгдэх нөхцөлд үзүүлнэ.

178. /B701_T/. Гудамжны нэр, хашааны хаягийг байр зүйн зурагт текст байдлаар оруулна. Оруулахдаа байр зүйн зургийн ачааллыг харгалзана.

8.13 Аж үйлдвэрийн байгууламж

8.13.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

179. /C101_A/. Байр зүйн зурагт хураасан нүүрс, элс, хайрга, үртэс, хөрс шороо, хог ургамал, илүүдэл хаягдал материал, ухсан, тэгшилсэн газрыг цэгэн хүрээгээр зурна. Ил задгай нүүрс, элс, төмөр бетон хавтан гэх мэт материал, бүтээгдэхүүнийг тогтмол нэг газарт хураадаг бол байр зүйн зурагт оруулна. Бага талбай эзэлсэн бол тайлбар бичиглэлийг хураангуйлна. Хөрс шороог тэгшилсэн газарт өвс ургамал ургасан бол овоолгын хүрээний дотор талд уг ургамлын Тэмдгийг зурна. Хэрэв уг талбайд мод, бут ургасан бол байр зүйн зурагт тайлбар бичихгүй, тэгшилсэн талбай гэж дүрслэхгүй. Ажлын даалгаварт энэ талбайд хаялбар татах эсэхийг тодорхой зааж өгөх бөгөөд хэрэв татвал тасархайгаар зурна. Үйлдвэрийн хог хаягдал, боловсруулж чадаагүй ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний овоолгод хаялбар татахгүй. Хог хаях зориулалтын газар нь газар дээрээ тодорхой хүрээ, хязгаартай бол байр зүйн зурагт байгаагаар нь дүрсэлнэ.

180-181. /C102_P- C102_A/. Үйлдвэрийн янданг бодит байрлалаар нь (жишээ нь: барилгын дунд, эсвэл өнцөгт, дэргэд гэх мэт). дүрсэлнэ. Хэрэв яндан нь масштабд дүрслэгдэх бол 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт түүний суурийн хэмжээгээр хүрээлж дотор талд нь “янд.” гэсэн тайлбар тавина. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт үүнийг масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ. 50 м-ээс өндөр янданг зурагт өндрийг нь м-ийн нарийвчлалтай бичнэ.

Энэ давхаргад уурын зуухны яндан, янз бүрийн засварын газар, нийтийн халуун усны янданг дүрсэлнэ.

182. /C103_P/. Байр зүйн зурагт газар доорх ашигт малтмалын орд газрыг /уурхай/ барилга, тээврийн байгууламж, цахилгаан дамжуулах, материалын агуулах, илүүдэл, хог хаягдал зэргийг хамт дүрсэлнэ.

Уурхайн амсрыг дотор нь үндсэн /ашиглалт, тээврийн, хүн буулгах/, туслах /агааржуулалт, ус гаргах, хайгуулын/ гэж ангилан түүний хөндлөн огтлолын төрхөөс хамааруулж янз бүрийн Тэмдгээр (дугуй, тэгш өнцөгт) дүрсэлж олборлож буй материалыг (жишээ нь: нүүрс, фосфор гэх мэт) бичнэ. Уурхайн налуу амсрыг нэмэлт шаардлагаар дүрсэлбэл Тэмдгийн дэргэд “нал.газ.”, “уурх.нал.амс.” гэсэн тайлбар бичиглэлийг бичнэ.

183. /C104_P/. Байр зүйн зураглалд цооногийг зориулалтаар нь - хайгуулын, ашиглалтын, туслах гэж ангилна. Эдгээр ангиллын нэрийг, “хайг.”, “ашигл.”,

"тусл" гэх мэт хураангуйлан бичнэ. Ажлын даалгаварт заасан бол цооногийн дугаар ба амсрын дэргэд газрын үнэмлэхүй өндрийг бичиж, 500 м-ээс бага гүнтэй гэж ангилна. Цооногийн дүрсийн дэргэд хүртвэрт - цооногийн зориулалтыг илэрхийлэх үсэг (газ.тос, хий гэх мэт) ба дугаарыг, хуваарьт - цооногийн газрын өндрийн тоотыг тус тус бичнэ. Бөглөсөн эсвэл хаягдсан цооногт "бөгл.цоон." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

184. /C105_P/. Амсарт уурхай, цооног, шурф нь нурсан бол байр зүйн зурагт нэг янзын Тэмдгээр дүрсэлж, нүхний гүнийг м-ээр үзүүлж ("нур.") тайлбар бичиглэлийг өгнө.

185. /C106_L/. Ил аргаар ашигт малтмалын ордыг олборлодог газрыг эзэлж буй талбайгаар нь дүрсэлнэ. Олборлолтын талбайд ашигт малтмалын нэрийг бичнэ. Ил уурхайг дүрслэхэд түүний гүний хэмжээг 0.1 м хүртэл нарийвчлалтай тогтоож өгнө. Дунджаар үнэмлэхүй өндрийн тоотыг уурхайн дүрслэлийн 3-4 см.кв бүрт өгнө. Ил уурхайд урт хугацаагаар ашиглахад зориулсан барилга байгууламж, замыг ердийн байдлаар дүрсэлнэ.

Ажиллаж буй ил уурхайд хаялбар татахгүй. Ажилладаггүй ил уурхайд хаялбар татна /Тайлбар 322-325/.

186-187. /C107_P – C107_L/. Геологи хайгуулын зориулалттай объектын бүрдэлд томоохон шуудуунаас гадна өөрийн овор хэмжээгээр багахан шуудуу, өрмийн цооног, геологийн суваг зэрэг багтдаг. Эдгээр шуудууг хоорондоо 0.5 мм зайтай тасалдалтай зураасаар зурж "геол." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Нэмэлт шаардлагаар тэдгээрийн дугаар ба геологи хайгуул хийсэн хугацаа зэргийг (жишээ нь: *геол. № 14, 1983* гэх мэт) бичнэ.

188-189. /C108_P - C109_P/. Газрын тос ба шатдаг хийн цамхгийн Тэмдгийг ашиглаж буй цооногт хэрэглэнэ. Энэ тохиолдолд цамхгийн Тэмдгийг цооногийн Тэмдгийн оронд зурна. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт дэргэд нь "газ.тос", "шат.хий" гэсэн тайлбар бичиглэл хийнэ. 1:500-1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт эдгээр байгууламжийн гадаад төрх ба түүний тулгуурыг /материалыг бүтээцээр нь ялгана. C201_P/ дүрсэлж, хүрээний дотор талд газрын тос ба хийн цамхгийн тогтоосон Тэмдгийг зурна. Дүрсийн дэргэд хүртвэрт - зориулалт ба дугаар, хуваарьт - цооногийн амсрын газрын өндрийн тоотыг ажлын даалгаварт заасан бол бичнэ. Түр хугацааны зориулалттай цооногийн цамхгийг зурагт дүрслэхгүй.

190. /C110_P/. Газрын гадаргын ойрхон давхаргаас газрын тос өргөх ердийн төхөөрөмжтэй газрын тосны худгийг нэг төрлийн Тэмдгээр дүрсэлж "газ.тос" гэсэн тайлбар бичиглэл хийнэ.

191-192. /C111_P - C111_A/. Газар дээрх газрын тос цуглуулдаг сан ба нүхийг байр зүйн зураг дээр дүрслэхдээ түүний овор хэмжээний дагуу зурна. Харин 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт масштабын бус Тэмдэг хэрэглэх бөгөөд "газ.тос" гэсэн тайлбар бичиглэл хийнэ.

193-194. /C112_P-C112_A/. Шатах тослох материал, шатдаг хий хадгалах ган савыг 1:500, 1:1000-ны масштабтай байр зүйн зурагт овор хэмжээгээр нь дүрсэлж тухай бүр тайлбар өгч тулгуурыг үзүүлнэ. 1:2 000-1:5 000-ны масштабтай зураглалд эдгээр объектыг масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ. Бензин буюу дизель хөдөлгүүрийн тос хадгалах савыг бүх масштабын зурагт үзүүлнэ. Шаардлагатай үед "бенз.", "диз." гэж бичнэ.

195-196. /C113_P – C113_L/. Машин засварын зориулалттай ашигладаг тавцанг тухайн масштабд илэрхийлэгдэх бол байрлалаар нь үзүүлнэ. Ажлын даалгаварт тусгайлан заасан, мэдээллийн сан үүсгэх зориулалтаар хийгдэж буй зурагт заавал үзүүлнэ.

197. /C114_P/. Үйлдвэр, тээвэр зэрэг салбарт хэрэглэдэг өөрөө өргөгч кран нь суурин, хөдөлгөөнт (рельс төмөр дээрх, дамжуур тавцан дээрх, өөрөө явагч),

эргэх, эргэлтгүй гэж байдаг. Хөдөлгөөнт хэд хэдэн өргөгчийг нэг рельс зам төмөр эсвэл дамжуур тавцан дээр байрлуулсан бол байр зүйн зурагт өргөгч бүрийн Тэмдгийг аль болох байрлалаар нь зурж оруулна.

198. /C115_P/. Зөгий үржүүлгийн газрыг масштабын бус таних Тэмдгээр дүрсэлж "зөгий" гэсэн тайлбар бичиглэлийг бичнэ.

199. /C101_T/. Аж үйлдвэрийн байгууламжийн хажууд бичигдэх тайлбар бичиглэлийг энэ давхаргад бичнэ. Жич: *хайгуул. ашиг*.

8.14 Цахилгаан, холбооны байгууламж

8.14.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

200-201. /C201_P – C201_L/. Шон ба татанга хоорондоо ялгаатай бөгөөд шон нь "нэг хөлтэй", татанга нь хоорондоо хатуу бүсээр холбогдсон "хөлтэй". Шонг байр зүйн зурагт тойргоор, татангын хөл бүрийг тэгш өнцөгтөөр тус тус дүрсэлнэ. Эдгээр тулгууруудыг байр зүйн зурагт материалаар нь ангилна. Татангын хөл бүрийг дүрслэх боломжгүй бол хөл бүрийн тоо, байрлалыг ерөнхийд нь төлөөлж чадах Тэмдгээр (тэгш өнцөгт - хоёр хөлтэй, дөрвөн хөлтэй тулгуурыг, гурвалжин Тэмдгээр - гурван хөлтэй тулгуурыг гэх мэт) дүрсэлнэ. Ямар ч шонг татлагатай буюу татлагагүй хувилбараар дүрсэлнэ.

202-203. /C202_P - C203_P/. Цахилгаан гэрлийн шон, гэрэлтүүлгийг 1:500-1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт бүрэн хэмжээгээр дүрсэлнэ. Зургийн агуулга, ачаалал хэт ихтэй тохиолдолд болон 1:2 000-1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт сонгон үзүүлж болно.

204-208. /C204_P – C207_L/. Цахилгаан дамжуулах шугам нь (ЦДШ) сүвгийн, утсан гэсэн 2 төрөл байдаг бөгөөд өндөр ба нам хүчдэлийн (380 в ба түүнээс бага) гэж хоёр ангилан үзүүлнэ. ЦДШ-ын татанга ба шонг 1:500-1:2 000-ны байр зүйн зурагт байгаа байрлалаар нь бүгдийг дүрсэлнэ. 1:5 000-ны барилгажсан талбайн зураглалд татангатай гол шугамыг дүрсэлж, эргэлтийн, эцсийн ба эхний тулгуурыг заавал оруулна. Хэрэв 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт зэрэгцээ хэд хэдэн ЦДШ-аас томоохон тулгуур бүхий шугам буюу хүчдэл ихтэй шугамыг сонгон дүрсэлнэ. ЦДШ-ын тулгуур хоорондох зай нь байр зүйн зурагт 1.5-2 см болон түүнээс их бол Тэмдгийн сумыг тулгуур бүрт зурна. Бүх ЦДШ-ын тулгуурыг байр зүйн зурагт үзүүлэхэд төмөр, төмөр бетон, мод /C201/ гэж ангилна.

ЦДШ-ын утас, кабель болон холбооны шугам нь нэг тулгуур дээр бэхлэгдсэн тохиолдолд байр зүйн зураг дээр зөвхөн ЦДШ-ыг дүрсэлнэ.

Барьж буй ЦДШ-ыг ердийн Тэмдгээр дүрсэлж "барь." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

Газар доорх цахилгааны кабелийн Тэмдгийн дэргэд "цах.каб." гэж бичнэ. Газар доорх цахилгааны кабельд үзлэгийн худаг байхгүй бол шугам явж байгаа газарт (эргэлт, уулзвар гэх мэт) болон байр зүйн зургийн 7-10 см бүрт кабель суулгасан яндан хоолойн дээд ба газрын гадаргын өндрийг бичнэ.

Талбайн онцлог болон зургийн ачаалал зэргийг харгалзан ЦДШ-ыг дүрслэхдээ нэмэлт шаардлагаар ЦДШ-ын Тэмдгийн дэргэд утасны унжилтын өндрийг бичнэ. Барилгажсан талбайд зөвхөн өндөр хүчдэлийн шугамын хүчдэлийг үзүүлнэ. ЦДШ-ын хүчдэлийг /кВ/ мэдээлэлд мөн оруулж өгнө.

209-214. /C208_P – C211_L/. Холбооны шугам ба удирдлагын техник хэрэгслийн шугамын төрөлд цахилгаан мэдээний, утсан харилцааны, радио нэвтрүүлгийн, телевизийн, дохиоллын гэх мэт шугамыг хамааруулан нэг төрлийн Тэмдгээр дүрсэлнэ.

Газар доорх ба агаарын холбооны шугам, удирдлагын техник хэрэгслийн шугамыг 1:500-1:2 000-ны масштабтай хот, суурин газрын байр зүйн зурагт үзүүлнэ. Эдгээр шугамыг 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт дүрслэхгүй.

Нэмэлт шаардлагаар тайлбар бичиглэлийг (жишээ нь: *тел. радио* гэх мэт) Тэмдгийн дэргэд хураангуйлсан үгээр */"рад."/*, */"ТВ."/* бичнэ. Хэрэв холбоо, удирдлагын техник хэрэгслийн шугам нь цахилгааны шугамтай хамт нэг тулгуур дээр бэхлэгдсэн бол зөвхөн цахилгааны шугамыг /Тайлбар 204-208/ үзүүлнэ.

1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зураг дээр газар доорх холбоо, удирдлагын техник хэрэгслийн кабелийн үзлэгийн худгийг тусгай Тэмдгээр дүрслэх бөгөөд өндрийг бичнэ. Өндрийг үзүүлэхдээ "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД 11-105-06-г баримтална. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт худгийн ирмэгийн өндрийг бичнэ.

Шилэн кабелийг байр зүйн зурагт газар дээрх, газар доорх гэж ангилан эргэлт, мурийлтыг байгаа байдлаар нь дүрсэлнэ.

215. /C212_P/. Бүх масштабын байр зүйн зурагт, радио телевиз, радиогийн цамхаг, радиорелей, радио өргөн нэвтрүүлгийн цамхгийг дүрслэхэд нэг төрлийн Тэмдэг хэрэглэнэ. Харин байгууламжийг өөрийн овор хэмжээгээр нь тулгуурын /C201_P/ хамт дүрсэлнэ. Эдгээр объектын дүрсийн дэргэд зориулалтын тайлбар бичиглэлийг хураангуйлан бичнэ. Телевиз, радиорелейний антен 50 м-ээс өндөр бол тэдгээрийн өндрийг бичнэ.

216. /C213_P/. Мэдээллийг алсад дамжуулахад радио долгионы тархалтыг ашиглаж байгаа холбооны системийг утасгүй холбоо буюу үүрэн холбоо гэж нэрлэдэг. Үүрэн холбооны антеныг байр зүйн зурагт байрлалаар нь цэгэн Тэмдгээр тэмдэглэж ямар үүрэн холбооны операторын антен болохыг мэдээлэлд оруулж өгнө

217. /C214_P/. Аянга зайлуулагчийг шонгийн материалаар нь ялгаж үзүүлнэ. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар дүрсэлнэ.

218. /C215_P/. Салхин сэнсийг овор хэмжээ, зургийн масштабаас хамааруулж зохих Тэмдгээр нь дүрслэх бөгөөд тайлбар бичиглэл хийж болно.

219. /C216_P/. Нарны энергийг хуримтлуулж эрчим хүч гаргах зориулалттай байрлуулсан зай хураагуурыг энэ давхаргад дүрсэлнэ.

220. /C217_P/. Тусгай карт, зоос ашиглан холбоо барих утсан харилцаа /нийтийн харилцуур утас/-ний төхөөрөмжийг энэ давхаргад дүрсэлнэ. Эдгээр нь байшингийн орц гарц, нуман хаалга дотор болон тусгай бүхээгт байрладаг.

221. /C218_P/. Телефон утасны байшингийн гадна байрлах түгээх шүүгээг байрлалаар нь 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт Тэмдгээр дүрсэлнэ. 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт зарим тохиолдолд дүрсэлнэ.

222-223. /C219_P - C220_P/. Хяналтын камер, худаг зэргийг байрлалаар нь тус тусын давхаргад зурна. Хяналтын камер нь кабель утастай бол түүнийг холбооны шугамаар үзүүлнэ.

224. /C221_P/. 4-8 талтай тусгал гэрэлтүүлгийг /прожектор/ энэ ангилалд хамааруулж дүрсэлнэ. Энэ төрлийн гэрэлтүүлэг нь ихэвчлэн 15м-аас дээш өндөртэй байдаг.

225-227. /C222_P - C224_P/. Нисэх онгоцны зурвас зам дагуу байрлах нислэгийн аюулгүй байдал, хөдөлгөөнийг зохицуулах гэрэл, налуу заагч гэрэл болон тоон ажиглалтын систем зэргийг зохих давхаргад ангилан үзүүлнэ.

Онгоцны гүйлтийн зам дагуух гэрлүүд нь нисэх онгоцны замын хязгаарын харуулах зориулалттай ба хөдөлгөөн зохицуулах үүргийг хүлээсэн өнгөөр солигдож асах буюу анивчдаг гэсэн хэд хэдэн төрөлтэй байна. Тоон ажиглалтын систем гэдэг нь хөдөлгөөн дулаан мэдрэх зориулалттай төхөөрөмж юм. Налуу заагч гэрэл гэдэг нь нарийвчлалттай ойртолтын ил харааны налуу заагч гэрлүүд юм.

228. /C225_A/. Долгион саармагжуулах, тусгай давтамжтай долгион хүлээн авах гэх мэт тусгай зориулалтын антенныг эдгээр давхаргад хэмжээ, байрлалаар нь үзүүлнэ. Эдгээр төрлийн антеннууд нь ихэвчлэн олон улсын нисэх онгоцны буудлын талбайд байрлана.

229-230. /C200_T - C201_T/. Цахилгаан, холбооны байгууламжийн тайлбар бичиглэл, үзүүлэлт энд бичигдэнэ. Жич: *рад., тр., дэд.ст., каб., 8Вт*

8.15 Шугам сүлжээ

8.15.1 Шугам сүлжээний зураглалыг 1:500, 1:1 000-ны масштабтай зураг дээр хийнэ.

8.15.2 1:2 000, 1:5 000-ны масштабтай шугам сүлжээний сэдэвчилсэн зургийг лавлах бүртгэл хөтлөх, төлөвлөлт хийхэд ашиглана.

8.15.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

231-246. /C301_P – C311_L/. Газар доорх байгууламжийг байр зүйн зурагт дүрслэхдээ зургийн масштаб, зориулалт (ердийн-байр зүйн, тусгай зориулалтын-сэдэвчилсэн) зэргээс хамаарч дүрсэлнэ.

Газар доорх байгууламжийн үзлэгийн /ил/ худгийг 1:500, 1:1 000-ны масштабын зурагт барилгажсан, барилгажаагүй эсэхийг үл харгалзан бүгдийг оруулна. 1:2 000-ны масштабтай зурагт зургийн ачааллыг харгалзан үзүүлж, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт үзүүлэхгүй. Зурагт үзлэгийн худгийг дүрслэхэд зөвхөн усан хангамж, ариутгах татуурга, үер бороо, дулаан, ЦДШ, кабель, холбоо болон удирдлагын техник хэрэгслийн байгууламжид хэрэглэх хувилбарыг авсан. Бусад төрлийн газар доорх байгууламжийн худгийг дүрслэхэд ердийн /бусад/ Тэмдгийг хэрэглэж зохих тайлбар бичиглэлийг (жишээ нь: "уурх.", "техм." гэх мэт) бичнэ.

Эвдэрсэн, дарагдсан худгийг байр зүйн зурагт "эвд.", "дар." гэсэн тайлбар бичиглэлийг өгч дүрсэлнэ.

Үзлэгийн худаггүй газар доорх шугам сүлжээнд өндрийг бичихэд Тайлбар 202-206-г баримтална.

1:500, 1:1 000-ны масштабтай сэдэвчилсэн зурагт нэмэлт шаардлагын дагуу /ажлын даалгаварт тусгагдсан/ газар доорх шугам сүлжээний төмөр зам, авто замтай огтлолцох хэсэгт байгаа хамгаалалтын гэрийг хоёр талаар нь тасалдалтай зураасаар (зураасны урт 2 мм) зурж, гэрийн материал, түүний урт, огтлолын хэмжээ, газар доор суулгасан гүн зэргийг бичнэ.

Шугам сүлжээг байр зүйн зурагт газар дээрх, газар доорх гэж ялган ангилал бүрээр нь дүрсэлнэ. Эдгээр Тэмдгүүдийг усан хангамжийг - хөх, ариутгах татуургыг - ногоон, дулааныг – улаан хүрэн өнгөөр зурна.

Шугам сүлжээний сэдэвчилсэн зурагт холбогдох инженерийн шугам сүлжээний байгууллагуудын архив, баримт бичиг, материалыг ашиглан – шугамын материал, доторх диаметр (мм), өөрийн урсгалтай шугамд урсгалтын чиг зэргийг оруулна. Газрын гадарга дээрх болон доорх ойрхон зэрэгцээ явах шугамд - 2НХ, 35 гэх мэт тайлбар бичнэ. Ажилладаггүй, барьж буй шугамыг (газар дээрх, доорх) зурагт дүрслэхдээ "аж-гүй.", "барь." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

Үерийн ус, цасны ус зайлуулах зориулалттай ховил, суваг, ил задгай шугам зэргийн Тэмдгийн хэлбэр нь түүний газар дээрх төрхтэй адил байна. 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт эдгээрийг тусгай шаардлагаар дүрсэлнэ. Хот, суурин газарт суваг, ил шугамын ёроол, хажууг ихэвчлэн бетоноор өнгөлсөн байдаг учраас 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт бэхэлгээний материалыг бичиж өгнө.

247. /C312_P/. Газар дээрх яндан хоолой, шугам сүлжээний тулгуурыг 1:500 - 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт үзүүлнэ. Яндан хоолойн доогуур автомашин гарах зориулалттай тулгуурын хэсэгт түүний өндрийг 0.1 м нарийвчлалтай бичнэ.

248. /C313_A/. Газар дээрх яндан хоолойн хорго, хоолойн хайрцаглагдсан хэсгийг талбайгаар зурна. Хайрцагласан хэсгийг зурахдаа хоолойн Тэмдгийн хоёр талаар зурж үзүүлнэ.

249-252. /C301_T - C306_T/. 1:500, 1:1 000-ны масштабтай газар доорх шугам сүлжээний сэдэвчилсэн зурагт үзлэгийн худагт өндрүүдийг үзүүлдэг. Өндрүүдийг үзүүлэхдээ “Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил” БД 11-105-06-г баримтална.

253. /C310_T/. Шугам сүлжээний тайлбар бичиглэл энэ давхаргад бичигдэнэ. Жишээ нь: *эвд.*, *дар.* гэх мэт

8.16 Ус, цаг уур

8.16.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

254-257. /C401_P-C404_P/. Ус, цаг уурын шинжилгээ хийхэд ашиглагддаг салхины хурд, чиглэл заагч, даралт температур, чийг хэмжигч, хур тунадас хэмжигч, үүлний өндөр хэмжигч зэрэг элементүүдийг эдгээр давхаргад байрлалаар нь үзүүлнэ. Эдгээр элементүүд нь ус цаг уурын мэдээлэлд ашиглагдахаас гадна олон улсын нисэх буудлын аюулгүй ажиллагаанд шаардлагатай байдаг.

258. /C400_T/. Ус, цаг уурын зориулалттай элементүүдийн хажууд бичигдэх тайлбар бичиглэл уг давхаргад бичигдэнэ.

8.17 Ус зүй

8.17.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

259-260. /E101_A – E101_L/. Гол мөрөн, нуурын эргийн шугамыг 1:2 000, 1:5 000-ны масштабтаар зураглахдаа бодит байрлалыг илэрхийлэхээс гадна усны хамгийн тогтвортой үеийн түвшинг үзүүлнэ. Харин 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт эргийн шугамыг зураглалын үеийн бодит байрлалаар нь үзүүлнэ. Усан сангийн эргийн шугам нь түүний ус хуримтлалын ердийн түвшин (ЕТ) болно.

Ус урсгуур, усан тогтцын эргийн шугамыг байр зүйн зурагт 3 хэсэг болгон хувааж, бие даасан Тэмдгээр тэмдэглэнэ:

1) байнгын ба тогтвортой;

2) тодорхой бус буюу байнга өөрчлөгддөг;

3) жилийн зарим цаг үед устай байдаг боловч эрэг, голдрил нь мэдэгдэхүйц гол, нуур цөөрмийн тогтворгүй эргийн шугам.

Байнгын тогтвортой эргийн шугамыг байр зүйн зурагт үргэлжилсэн шугамаар, хатаж ширгэдэг бол тасархай шугамаар үзүүлнэ. Цэнхэр суурь өнгийг голдрилын дагуу хийж өгнө.

Гол, горхи, мөрнийг тухайн масштабд өргөн нь илэрхийлэгдэх байдлыг харгалзан дан буюу давхар шугамаар зурна. Хэрэв байр зүйн зурагт урсгал усны өргөн нь тухайн байр зүйн зурагт эргийн шугамын хамт 0.5 мм-ээс их бол давхар шугамыг хэрэглэнэ. 1:5 000-ны масштабтай зураглалд 2.5 м өргөн голдрилтой голыг давхар шугамаар үзүүлнэ. Байнгын устай гол горхины урсгал усны өргөнийг 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт заавал үзүүлэх ба урсгал усны өргөнийг шууд хэмжилтээр тодорхойлно. Нэмэлт шаардлагаар 1:500, 1:1 000-ны

масштабтай байр зүйн зурагт голдрилын өргөний тодорхойлолтыг 0.1 м нарийвчлалтай тодорхойлно. Гол горхины гүнийг үзүүлэхдээ хамгийн гүн газар 0.1 м нарийвчлалтай бичнэ.

Байр зүйн зурагт усны үзүүлэлтийг дүрслэх, тодорхойлолт өгөхдөө усны түвшнийг үзүүлэхээс гадна урсгалын чиглэл, хурд, ёроолын хөрсний тодорхойлолтыг өгнө. Нэмэлт шаардлагаар бохирдсон урсгал усны нэрээс гадна нэмэлт тайлбар бичиглэлийг (жишээ нь: Бааст (бохирд) гол) өгнө.

Байр зүйн зурагт урсгал усны ёроолын хөрсийг доорх байдлаар ангилна:

- чулуулаг (тэгш бус хадан гадарга, том чулуунууд) үүнийг байр зүйн зурагт "Ч" үсгээр, хатуу (жигжиг чулуун ба дагтаршсан шавар) үүнийг "Х" үсгээр, дагтаршсан элсэн, үүнийг "Э" үсгээр, лаг шаварлаг (лаг шавар, шаварлаг) үүнийг "Л" үсгээр тус тус ангилж тэмдэглэнэ.

261-262. /E102_A – E102_L/. Хатдаг, ширгэдэг голын эргийн шугамыг тасархай шугамаар дүрсэлнэ. Цэнхэр дэвсгэр өнгийг голдрилын дагуу хийж өгнө.

263-264. /E103_A – E104_A/. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт нуурыг бүхэлд нь харин 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт 5 мм.кв ба түүнээс том хэмжээтэйг болон эмчилгээний зориулалттай нууруудыг оруулна. Эдгээрийн талбайг тусгайлан томсгож үзүүлэх тал бий. Нэргүй, тодорхой заагтай гүехэн нуурыг ойр орчмын объектуудаас ялган үзүүлэхийн тулд "нуур" эсвэл "Н." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Шорвог, давстай нуурыг "давстай" гэх мэт тайлбар өгөх ба тухайн нуур нэртэй бол нэрний ард нь "Буйр н. (давстай)" гэсэн тайлбар бичиглэлийг хийнэ.

265. /E105_L/. Голын тэнхлэгийн шугамыг голын салаа, далантай бол далан хоорондын тэнхлэгээр зурж тухайн гол, мөрөн, булагтай холбоотой мэдээллийг оруулж өгнө.

266. /E106_P/. Зураглалын ажлын даалгаврын дагуу усны түвшинг байр зүйн зурагт оруулахдаа зураглал үйлдсэн он, сар, өдрийн байдлаар буюу олон сарын дундаж түвшнээр үзүүлнэ. Нэмэлт шаардлагаар энэ хоёр тодорхойлолтыг Тэмдгийн хамт үзүүлнэ. Усны түвшний өндрийн хамт он, сар, өдрийг хамт заах бол тухайн газрыг шинээр зураглах болон 2 ба түүнээс олон жилийн өмнө зурагласан тохиолдол байна. Усны түвшний өндрийг 0.1 м-ийн нарийвчлалтай тодорхойлно. Харин тэгш газрын ус урсгуурын (налуу багатай) түвшний өндрийг тусгай шаардлагаар тодорхойлно.

267-268. /E107_A – E107_L/. Том горхины ширгэж арилсан хэсэг бодит байдалд түүний байрлалыг тодорхойлж болох ямар нэг шинж тэмдэг байгаа тохиолдолд Тэмдгийг хэрэглэнэ. Тодорхой мэдэгдэхгүй тохиолдолд голдрилыг үзүүлэх (жишээ нь: хэсэг газар хөрсөнд урсгал нь шилжиж, хэдэн км-ийн алсад дахин ил гарсан) шаардлагагүй.

269. /E108_L/. Урсгалын чиглэлийг усан дээр сумаар, өргөнтэй нь харьцуулан зурж үзүүлэх ба хэрэв гол нь тухайн масштабаар илэрхийлэгдэхгүй бол голдрилыг дагуулан зурна.

Усны урсгалын хурд нь байр зүйн зураглалын явцад хэд хэдэн удаа тодорхойлогдсон эсвэл ус зүйн материалд үндэслэгдсэн усны гадарга дээрх дундаж хурд болно. Урсгалын чиглэл, хурдны тодорхойлолтыг байр зүйн зурагт 10-15 см бүрт мөн эхэн ба төгсгөлд (хаалт далангийн дээр, доор нь, хүрхрээ зэрэгт) голын уулзвар хэсэгт өгнө.

270. /E109_P/. Байгалийн булаг, шандыг байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр урсгалын чиглэлийг харгалзан үзүүлнэ.

Байгалийн бүх төрлийн булаг, шандыг үзүүлэхэд тайлбар бичиглэл хэрэглэнэ. Ердийн устай булаг шандад "бул". "шанд." гэх мэт тайлбар бичиглэл өгнө. Эрдэстэй булаг, шандад эрдсийг нь "нүүрс ус", "хүхэр" гэх мэт заах ба эрдэс нь тодорхойгүй бол "эрдэст" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Ус багатай газар

нутгийн булаг, шандад ус хангамжийн өгөгдлийн дагуу ундаргыг л/цаг-аар тодорхойлно. Булаг, шандны дэргэд гадаргын үнэмлэхүй өндрийг бичнэ.

271. /E110_P/. Халуун уур, ус байнга оргилон гардаг эрдэс бүхий байгалийн тогтцыг оргилдог рашаан гэнэ. Оргилдог рашааныг Тэмдгээр үзүүлж гадаргын үнэмлэхүй өндрийг бичнэ.

272-273. /E111_A – E112_A/. Намгийг байр зүйн зурагт байнгын ихээхэн чийглэгтэй, намгийн ургамалтай 30 см түүнээс зузаан хүлэр давхаргатай (хүлэр тогтох аятай нөхцөл бүрдээгүй, тал болон өндөр уулын намгаас бусад) газрыг хамруулан үзүүлнэ. Намгийг жилийн тунадас, улирлын мөчлөг, туулах (нэвтрэх) боломжоор нь хувааж үзүүлдэг. Гатлах боломжтой намагт хүн дуртай чиглэлд чөлөөтэй туулж болох намаг хамаарна. Бусад төрлийн намгийг гатлашгүй, гатлахад хүнд гэсэн Тэмдгээр үзүүлнэ. Гатлах боломж нь янз бүр намаг бүхий газрыг зурагт 1 см.кв, түүнээс томоор үзүүлэгдэх тохиолдолд зааглан зурна. Гэхдээ намгийн хязгаар газар дээрээ тодорхой мэдэгдэж байх ёстой. Намаг, намгархаг газартай нийлэх хязгаар нь сайтар ялгагдахгүй байвал зааг хязгаарыг ойролцоогоор үзүүлнэ.

Байр зүйн зурагт хэрэглэгдэх намгийн гүний үзүүлэлт нь гадаргын бүрхүүл, эрдсийн ёроол хүртэлх хүлрийн зузаан зэргийн нийлбэр бөгөөд энэ нь намгийн гатлах шалгууртай шууд холбогдолгүй болно. Намгийн үзүүлэлтийг 2.5 м хүртэлх гүнийг нь хэмжсэний үндсэн дээр 0.1 м нарийвчлалтайгаар тогтооно. Хэрэв хүлрийн зузаан 2.5 м-ээс их бол "2.5 м-ээс гүн" гэсэн бичиглэл хийнэ. Хүлэр хайгуулын ажилтай холбогдсон газрын хувьд намгийн гүнийг бодит гүнээр нь (-4.5 м гэх мэт) тогтооно.

Намаг нь үргэлж ургамлаар бүрхэгдсэн байдаг тул тэдгээрийг хөвдтэй, тачир өвстэй, өндөр өвстэй, буттай, сөөгтэй гэх мэтээр ангилна ургамлын төрлийн Тэмдгийг тухайн талбайд нь тараан тэгш байрлуулж зурна.

274. /E113_P/. Намгархаг газрыг нарийн суваг, жалга даган үүссэн цэцгэн хэлхээгээр хучигдсан, тодорхой улиралд гэсч хайлдаг, хөрс нь нэвтрэх боломжтой намгийг бодвол чийглэг шаарддаг тачир ургамал, бага хэмжээний хүлэртэй эсвэл огт хүлэргүй байдлаар нь тодорхойлно.

275-276. /E114_A – E115_A/. Гатлах боломжтой, гатлахад хүнд, хужир марзын Тэмдгийг байр зүйн зурагт үйрмэг хөрс, нойтон хөөмөл (дулааны улиралд), хужир марз, мөн усан тогтцын эргээр тогтож хатсан давслаг шавар зэрэгт хэрэглэнэ. Нэвтрэх боломжийг ялган хүн нэвтэрч чадах боломжоор үнэлнэ. Ийм хужир марзыг тэдгээрийн хэмжээ хязгаараас үл хамааран зааглана. Гатлах боломжтой хужир марз бүхий газарт давслаг хөрстэй, хатуу гадаргатай, ургамалгүй, гадарга дээр нь давсны зурвас үүссэн, бут сөөг тохиолдох газар хамаарна. Хэрэв байр зүйн зурагт 1 см.кв, түүнээс томоор дүрслэгдэх тодорхой хязгаартай бол түүнийг зааглана.

277. /E116_L/. Байр зүйн зурагт гол уулын болон нууруудын дундах ижил бус түвшинтэй хүрхрэнүүдийг үзүүлнэ. Цас хайлах болон борооны дараа үүсдэг байнгын бус хүрхрээг байр зүйн зурагт үзүүлэх шаардлагагүй. Байр зүйн зургийн масштабт 2 мм-ээс өргөнгүй дүрслэгдэх хүрхрээг зураасаар тэмдэглэнэ. Энэ шугам нь хүрхрээний бодит хэлбэрийг илэрхийлсэн, зураас нь урсгалын дагуу зурагдсан байх ёстой. Хүрхрээний Тэмдэгт "хүрх." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

278. /E117_L/. Голын боргио нь уулын нуралт, мөсөн голын урсалт зэргээс үүссэн бул чулуу эсвэл байгалийн үндсэн хатуу чулуулгаас үүсдэг. Байр зүйн зураглалд түүний өргөн, уртыг харгалзан "борг." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт 2 мм ба түүнээс томоор дүрслэгдэх бол тэмдэглэнэ.

279. /E118_A/. Голын харгиа гэж - өргөсөж, гүехэн болсон голын голдрил болон голын адгийн хэсгийг хэлнэ. Харгиаг байр зүйн зурагт эзэлж байгаа талбайг нь харгалзан Тэмдгээр үзүүлнэ.

280-281. /E119_P – E119_A/. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт ус зүйн материалд тулгуурлан усан сангийн тодорхойлолтыг 10 см.куб ба түүнээс томоор дүрслэгдэх бол талбайг бүхэл км.кв-ээр, эзлэхүүнийг бүхэл км.куб-ээр, 0.1-10 км.куб усан санг 0.1 км.куб-ээр, 0.1-0.01 км.куб усан санг 0.001 км.куб-ээр тус тус үзүүлнэ. Газар доорх болон задгай усан санг бодит хэмжээ, байрлалаар нь байр зүйн зурагт үзүүлнэ. Масштабын бус тэмдгийн хажууд "ус.сан" гэсэн тайлбар бичиглэлийг хийнэ.

282. /E120_A/. Усны түвшин нь байнга өөрчлөгддөг 20 мм ба түүнээс өргөнөөр зурагт дүрслэгдэх нуур, усан сангийн эргийн зурвасыг байр зүйн зурагт түүний хөрсний бүтцээр нь ангилан зураглана. Энэ тохиолдолд элсэрхэг, лагшаварлаг, хайрга-чулуутай хөрсийн аль зонхилох хөрсөөр нь цэнхэр дэвсгэр дээр ялган тэмдэглэнэ.

283. /E121_A/. Том нуурын их усны хувьд ашиглагдах устай байх үеийн байдлаар нь үзүүлнэ. Энэ Тэмдгийг байр зүйн зургийн ачааллыг ихэсгэхгүй байхаар тооцож оруулна. Том масштабын байр зүйн зурагт үерийн хилийг тусгай нэмэлт шаардлагаар үзүүлнэ. Үерийн усны хилийг дор дурдсан нөхцөлд үзүүлнэ:

- хоёр сар ба түүнээс урт хугацаанд байх их усны ус (үргэлжилсэн бороо, цас хайлалт, далангаар дамжих ус гэх мэт);

- их усны зурвасын өргөн 1:2 000-д 2.5 см, 1:5 000-д 1 см-ээс тус тус их байхад, их усыг үзүүлэхдээ хамгийн их устай байсан үеийн агаарын гэрэл зураг буюу ус зүйн байгууллагын материалыг ашиглах хэрэгтэй. Эдгээр нь үргэлжилсэн бороо хурнаас болж, байнга устай байдаг ус хагалбар бүхий газрын байр зүйн зургийг зохиоход нэн ач холбогдолтой. Голын хамгийн их устай үеийн тодорхойлолтыг нэмэлт шаардлагаар зурагт үзүүлэх бөгөөд тайлбарыг хар өнгөөр бичнэ. "их ус IV-VI"

284. /E122_A/. Усны урсгалд түрэгдсэн мод, мөчрийн бөөгнөрлийн Тэмдэг нь давлагаагаар эрэгт хаягдсан мод, гишүүний бөөгнөрлийг үзүүлэхэд зориулагдана. Үүнд онгоцны сэг, мод бусад ургамлын зүйл орно.

285-287. /E101_T, E106_T, E108_T/. Нуур, гол, булаг зэрэг ус зүйн элементүүдийн оноосон нэр, үзүүлэлт болон усны урсгалын хурд зэрэг нь эдгээр давхаргуудад бичигдэнэ.

8.18 Усны байгууламжууд

8.18.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

288-291. /E201_P – E204_P/. Ус хуваарилах цэгийн байрыг байр зүйн зурагт бодит хэмжээгээр нь орон сууцны бус барилгаар дүрслэн дотор нь хийц материал, зохих масштабын бус Тэмдгийг тавина. Гар /ховоотой/, мотортой, эргүүлдэг, дүүжинтэй худгийг байр зүйн зурагт үзүүлэн худаг "Х.", гэсэн хураангуйлсан нэр буюу тодорхой нэрийг байрлуулна. Давстай, шорвог устай худагт "давст.", эсвэл "шорв." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Суурин газраас хөндий байрласан худгийг байр зүйн зурагт заавал оруулах ба шаардлагатай бол сонголт хийж 1 дм.кв. талбайд 2-3 худаг байхаар бодож зураглана.

Дарагдсан худгуудыг "Х." (дар.) гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

292-293. /E205_P- E205_A/. Дээшээ буюу доошоо ус цацруулах ба олгойдуулах гидротехникийн төхөөрөмжийг усан оргилуур гэнэ. Усан оргилуур ихэвчлэн дугуй хэлбэртэй байна. Байр зүйн зурагт тэдгээрийг масштабын бус

Тэмдгээр тэмдэглэх ба хэрэв усан оргилуур томоохон хэмжээтэй бол зураасаар хүрээлж дотор нь зохих Тэмдгийг тавина.

294-295 /E206_P – E206_A/. Шон болон тулгуурт байрлуулсан усны ганг 1:5 000-ны масштабын байр зүйн зурагт Тэмдгээр тэмдэглэж "ус" гэсэн бичиглэл хийнэ. Бусад масштабын байр зүйн зургийн хувьд эдгээр ганг байгаа байрлалаар нь зураглаж /тулгуурыг Тэмдэг C201_P-ээр/ хийц материалыг нь заана.

296. /E207_L/. Гатлага төхөөрөмжийг механик хөдөлгүүртэй гатлага онгоц, өөрөө явагч буюу чиргүүл, тросс зэргийн тусламжтай ажиллах сал, бярвааз, хөвөгч гэх мэт ангилна. Эдгээр гатлагуудыг 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт Тэмдэг, урт, өргөн, даацын тодорхойлолтын хамт үзүүлнэ. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт зөвхөн даац бичигдэх ба бодит байрлалаараа зурагдан "гатл." эсвэл "бяр." гэсэн тайлбар бичиглэлтэй байна.

297. /E208_L/. Явган ба авто тээврийн голын олом, гармын Тэмдгийг газар дээрх бодит байрлалаар нь байр зүйн зурагт үзүүлнэ. Гармын тэмдэг голын нэгэн адил тодорхойлолттой байх бөгөөд үзүүлэлтийн байрлал нь өөр байна Тухайлбал: хуваарьт - хамгийн их гүн ба урт (зөвхөн 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт), хүртвэрт - хөрсний төрөл ба урсгалын хурд бичигдэнэ. Хөрсийг чулуулаг, хатуулаг, элсэрхэг, шаварлаг гэж хуваах ба ангиллын шинж төрхийг Тайлбар 259-260-д үзүүлэв.

298. /E209_P/. Усан тогтоц, урсгалаас ус хуримтлуулах, сорох, элдэв бохирдлоос цэвэрлэх, хонгил болон сувагт ус дамжуулах зориулалттай байгууламжийг ус сорогч гэнэ. Усан хоолойд ус дамжуулах, гаргах зориулалтын шахуургын агрегат бүхий байгууламжийг шахуургын станц гэнэ. Ус сорогч, шахуургын станцыг нэгтгэн гидротехникийн зангилаа болгон усан цахилгаан станц, усан тээврийн хэрэгсэл, усжуулалт, газрын хөрс сайжруулах зорилгыг хангах зориулалтаар байгуулдаг. Ийм зангилааг байр зүйн зурагт объект бүрийн гадаад төрх байдлыг үзүүлэх ба "ус сор.", "ус шах.ст." гэх мэт тайлбар бичиглэлийг өгнө.

299-300. /E210_P – E211_P/. Ус хангамжийн түгээгүүрийг байр зүйн зурагт дор дурдсан хэсэг болгон ангилна:

- усан даралтын өөрөөр хэлбэл хоолойгоор ус дамжуулах;
- ус хуваарилалтын - ахуйн хэрэглээний зориулалттай;
- ундны, хот, цэцэрлэг, цэцэрлэгт гудамж, усанд орж, наранд шарах газрын

"уух оргилуурт";

- хаагууртай, ус дамжуулах шугам сүлжээнээс ус авах, түймэр унтраах ба услах зориулалтын гэх мэт.

301. /E212_L/. Усжуулалт, ус дүүргэлтийн сувгийн ус хуваарилах байгууламж хийцийн хувьд олон төрөлтэй байдаг. Ус хуваарилах байгууламжийг газар дээрх бодит байрлалыг нь харгалзан аль тохирох Тэмдгийг хэрэглэн байр зүйн зурагт оруулна. Тусгай зориулалтын сэдэвчилсэн зурагт ус хуваарилах байгууламжийн сувгийн усны түвшин, ус гаргалтын түвшин, гадаргын болон байгууламжийн дээд түвшин зэргийг тодорхойлно.

302. /E213_L/. Эргийн хаалт, хашлагыг байр зүйн зурагт дүрслэхдээ 2 хэсэг болгон дүрслэх ба босоо, налуу гэж ангилна:

- чулуун,
- бетон ба төмөр бетон;

Босоо эргийн хашлага дагуу "босоо" гэсэн тайлбар бичиглэл хийх ба зай бага бол "бос." гэж хураангуйлан хийц материалыг "чул.", "бет." гэх мэтээр заана. Эргийн хашлагыг байр зүйн зурагт оруулахад эргийн үнэмлэхүй өндөр, усны түвшинг тодорхойлно.

1м түүнээс өндөр эргийн хашлаганд зориулагдсан аюулгүйн хөдөлгөөний хамгаалалтын үргэлжилсэн ханыг хаалт гэх ба тэдгээрийг усны хаалт, далан, гүүр, огцом эргэлттэй авто машины зам зэрэгт байгуулдаг.

303. /E214_A/. Усан замын боомтын зогсоолыг байр зүйн зурагт үзүүлэхэд: тоноглогдсон, тоноглогдоогүй гэж ангилна. Тоноглогдсонд усанд зоогдсон тулгуур суурьтай эргийн зогсоол мөн хөвөгч төхөөрөмж багтана. Эдгээр зогсоолыг бодит байдлаар нь зохих хэмжээгээр нь зураглана.

304. /E214_P/. Тоноглогдоогүй зогсоол цэгийг байр зүйн зурагт зангуу хэлбэрийн тусгай Тэмдгээр эргийн шугамын ойр усны мандлын дүрслэлд зурж үзүүлнэ. Иймд 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт хөлөг онгоцны зангуут зогсоолыг булан тохойн эргийн ойролцоо зурж үзүүлнэ.

305-306. /E215_P – E216_P/. Хөлөг онгоцны байрлал тодорхойлох, усан замын аюултай газрын анхааруулга, эрэг, эх газрыг танин мэдэх зэрэг чиглүүлгийн зориулалттай, эрэг дээрх буюу хөвөгч байгууламжийг гэрэлт цамхаг гэнэ. Эдгээрийг гэрэлт дуран авайн систем эсвэл дохиоллын хэрэгслээр, өөрөөр хэлбэл агаарын дуу баригч болон радио техникийн хэрэгслүүдээр тоноглоно. Эргийн гэрэлт цамхгуудыг нэг Тэмдгээр, хөлөг онгоцонд байрлуулсан тусгай хийцийн болон зангуугаар бэхэлсэн хөвөгч гэрэлт цамхгуудыг өөр Тэмдгээр тэмдэглэнэ. Тусгай шаардлагаар "гэрэлт", "дуу баригч", "радио техн." гэх мэт тайлбар бичиглэлийг хийнэ. Хэрэв гэрэлт цамхаг нь байшин хэлбэртэй, байр зүйн зурагт зурагдах боломжтой бол орон сууцны бус барилгаар /B102_A/ зурж зохих тайлбар бичиглэлийг хийнэ. Хэрэв гэрэлт цамхаг нь шон хэлбэртэй бол бодит байрлалаар нь байр зүйн зурагт оруулж хийц материалыг заана.

307. /E217_P/. Усан замд зориулагдсан эргийн гэрэлт тэмдэг, гэрэлт цамхагас бага хүчтэй оптик-гэрлийн систем, нам хийцтэй байгууламжтай шон дээр эсвэл эргийн түвшинтэй ижил эрэг дээр байрласан байдгаараа ялгаатай. Хэрэв гэрэлт тэмдэг байрлуулсан шонгийн суурь масштабд илэрхийлэгдэж байвал тухайн объектыг үзүүлэх аргачлал нь /Тайлбар 305-306/ гэрэлт цамхгийг үзүүлэх аргачлалтай ижил байна. Ямар нэг барилга, үйлдвэрийн байгууламж дээр (үйлдвэрийн яндан, газрын тосны болон шатдаг хийн цамхаг дээрх гэх мэт) байрлуулсан анхааруулах зориулалтын гэрэлт тэмдгийг байр зүйн зурагт үзүүлэхгүй.

308. /E218_P/. Байр зүйн зурагт зөвхөн усан сан, гол мөрөн дээрх онгоцны зогсоолын шулуун (цуваа) болон бусад байнгын чанартай эргийн дохиоллуудыг оруулна. Эдгээр тэмдэг нь усан тээврийн хөдөлгөөнөөс шалтгаалан өөрчлөгддөггүй болно.

309. /E219_P/. Хөвүүр дохио нь усан замд зангуугаар бэхлэгдсэн чиглүүлэгч тэмдэг болно. Түүнийг усан тээврийн аюултай газрыг тусгаарлах, усан доорх ямар нэг зүйлийн байрлалыг заах зориулалтаар байгуулна. Хөвүүр дохио нь гэрэлтүүлэгтэй, дуун дохиотой, радио техникийн төрлүүдтэй бөгөөд байр зүйн зурагт зохих Тэмдгүүдээр үзүүлнэ.

310-313. /E201_T, E202_T, E206_T, E208_T/. Худгийн оноосон нэр, үзүүлэлт, олом гарамны үзүүлэлт, усны бусад байгууламжийн хажууд бичигдэх тайлбар бичиглэлүүд эдгээр давхаргад орно.

8.19 Мөнх цас, мөсөн гол

8.19.1 Уулын оройд цасан дээр цасны нягтралаас үүссэн бутрамтгай талст бүхий мөсөн давхаргыг мөнх цас гэнэ. Мөнх цасны гадарга нь мөсөн голын эх болох бөгөөд энэ нь гүнзгий хагаралтай тогтсон байдаг. Мөнх цас нь байр зүйн зурагт тэгш байрлуулсан цэнхэр цэгүүд ба хаялбараар үзүүлэгдэнэ. Мөнх цас түүнээс сунаж гарсан хэсэг бодит байрлалаар болон агаар-сансрын зурагт цасан бүрхэвчээс ялгагдаж байвал түүний заагийг Тэмдгээр хязгаарлан зурж үзүүлнэ.

8.19.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

314-316 /E301_L – E303_L/. Уулын хөндийг даган урсаж сунасан, зарим хэсэгтээ дагуу ба хөндлөн хагаралтай, цасан нягтрал бүхий бөөгнөрлийг мөсөн гол гэнэ. Мөсөн гол, мөнх сарьдгийн хязгаарыг аль болох бүтэн тодорхой үзүүлэх хэрэгтэй. Ялангуяа цасанд түрэгдсэн чулуулаг эсвэл цасан бөөгнөрлийг ялган үзүүлэх нь чухал юм. Мөсөн голын хилийн доод төгсгөлд өндрийг заавал тодорхойлно.

317. /E304_L/. Янз бүрийн хэлбэртэй мөсөн голын хагарал, ангал нүхийг дан ба давхар өргөн шугамаар тэмдэглэнэ. Мөсөн голын ангальг байр зүйн зурагт хэлбэрийг нь ерөнхийлөхгүйгээр бүгдийг үзүүлэх ба 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт сонголтоор үзүүлж болно.

318. /E305_P/. Хэдэн м-ээс хэдэн зуун м-ийн гүнтэй, 5-10 м түүнээс өргөн диаметртэй, гол төлөв босоо дугуй хэлбэрийн нүхийг мөсөн голын худаг гэнэ. Энэ нь усны хайлалтаас мөсөн голын хагарал дотор үүснэ. Мөсөн голын худгийн гүнийг шаардлагатай бол 1.0 м нарийвчлалтай үзүүлнэ.

319. /E306_A/. Жилийн дулаан улиралд ч хайлдаггүй цасан бүрхэвч хөр цасыг байр зүйн зурагт үзүүлнэ. Өөрөөр хэлбэл дулаан улиралд цас бүрэн хайлсны дараа үлдсэн тухай масштабд илэрхийлэгдэх хөр цас болно.

320. /E307_L/. Мөсөн эрэг, саад тэдгээрийн зузаан нь газрын гадарга эсвэл усан тогтцын түвшингээр тодорхойлогдоно. Байр зүйн хувьд тэдгээрийг зөвхөн уртаар нь ялган үзэх бөгөөд мөсөн саад, гол төлөв эх газар эсвэл мөсөн голын төгсгөлийн шинж байдлаар тодорхойлно. Томоохон хэмжээтэй нь өөрийн нэртэй байдаг.

321. /E306_T/. Мөнх цас, мөсөн голын тайлбар бичиглэл энэ давхаргад бичигдэнэ. Жич: *дошин., мөс.овоол.*

8.20 Газрын гадарга

8.20.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

322-325. /F101_L- F104_L/. Хаялбарыг бүх төрлийн байр зүйн зурагт газрын гадаргыг дүрслэхэд зориулан зурна. Усан тогтоц, гол мөрөн, суваг, 3 мм-ээс багагүй өргөн ёроолтой голын хуурай голдрил, ганга жалга, үйлдвэрлэлийн зориулалттай уурхайн карьер, ухсан газар, овоолго, далан, довцог зэргийг хаялбараар дүрслэхгүй. Мөн барилгын талбайд хаялбарыг үзүүлэхгүй. 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт нэмэлт шаардлагаар хаягдсан уурхай, хүлэр боловсруулах, хуучин карьер, үйлдвэрийн газрын хог хаягдал бүхий хэсэгт хаялбар татна.

Хот суурин газрын гудамж талбай, барилга, зэрэгт ажлын даалгаварт заасан бол хаялбарыг зурж болно.

Тодруулсан, үндсэн хаялбарыг түүний ойлгогдох ерөнхий байдал хэлбэрийг дээшлүүлэх, газрын хэвлийг тодорхойлох ажлыг хөнгөвчлөх зориулалтаар зурна. 1.2-5 м үеийн өндөртэй хаялбарын 5 дахь хаялбар, 0.5-2.5 м үеийн өндөртэй газарт 4 дэх хаялбарыг тус тус өргөнөөр зурна.

Нэмэлт хаялбарыг газрын хотгор гүдгэр хэлбэр үндсэн хаялбараар дүрслэгдэхгүй, мөн эгц хясааны өөрчлөлтийг үзүүлэхэд хэрэглэнэ.

Туслах хаялбар нь байр зүйн зургийн хамгийн өндөр оргил, хамгийн хонхор газар, газрын гадаргын бичил хаялбарыг (тухайлбал: ганга жалга гэх мэт) үзүүлэхэд ашиглагдана. Туслах хаялбар дурын өндөртэй зурагдана.

Хаялбарын өндөр заасан тооны толгойг өндөр чиглэлд байр зүйн зургийн доод ба зүүн захыг дагуулан бичнэ. 0.5 ба 2.5 м үеийн өндрөөр зурагдсан хаялбарын нэрийг аравтын оронтойгоор бусад үеийн өндөрт бүтэн м-ээр 1112.5, 1120 бичнэ. Хаялбарын өндрийг тухайн байр зүйн зурагт байгаа өндрийн

цэгүүдтэй холбон ямар ч цэгийн өндрийг хурдан тодорхойлох нөхцөлийг харгалзан өгнө.

326. /F105_L/. Ус хагалбарын шугамыг (бергштрих) хаялбарт, хотгор гүдгэрийг тодотгох, оргил, хонхор зэрэгт мөн бага налуутай газар, байр зүйн зургийн захын хэсэгт зурж үзүүлнэ.

327. /F106_P/. Байр зүйн зурагт байвал зохих өндрийн цэгүүдийн тоог ажлын даалгаварт заах бөгөөд эдгээр нь байр зүйн зурагт тодорхой цэгүүдийг оролцуулан дунджаар 1 дм.кв-д 5-15 цэг байна. Хөрс сайжруулах зориулалттай сэдэвчилсэн зурагт тусгай шаардлагаар өндрийн цэгийн тоог 3-4 дахин ихэсгэж болно.

328. /F107_L/. Олон жил усны үйлчлэлээр идэгдэж эвдэрсэн газрыг байр зүйн зурагт ганга, нарийн жалга, гуу, идэгдсэн гуу гэж ангилахаас гадна энэ хэлбэрт хуурай голдрил, үйрмэг шороо зэрэг хамаарна. Жалгын уртыг илэрхийлж байгаа зураасны урт нь дүрслэгдэж буй жалганы хавтгайд буулгасан тусгаг болно.

Зургийн масштабд 1.5 мм түүнээс бага өргөнөөр ганга дүрслэгдэж байвал түүнийг эгц эргийн Тэмдгээр хүрээлэн зурж үзүүлнэ. Налуу эрэг бүхий гангыг нэлээд урт зураасаар үзүүлэх ба ёроол өргөн зурагт 3 мм ба түүнээс их бол хуурай сайраар хаялбарыг хязгаарлаж, ганганы хөндлөн огтлолын хэлбэрийг хадгалж дүрслэгдэнэ. 0.5-1.5 мм өргөнтэй дүрслэгдэх ганга, жалга, гууг хос өргөн шугамаар үзүүлнэ. Тухайн масштабт 0.5 мм-ээс бага өргөнтэй гууг дан шугамаар үзүүлнэ. Энэ тохиолдолд жалга, гууны гүн ба дээд өргөнийг 0.1 м нарийвчлалтай тодорхойлж бичнэ.

329-330. /F108_A - F108_L/. Урт хугацаанд усны нөлөөллөөр үүссэн жижиг хуурай голдрил, үйрмэг шороо зэрэг нь ганга, голын дэнж, хөндийн хэвгий зэрэг ус хагалбарын зайнд тохиолдоно. Гадаргын ийм хэлбэрийг байр зүйн зурагт 0.2-0.5 мм хүртэл хос тасархай шугамаар эсвэл өргөн нь масштабд илэрхийлэгдэж байвал усны эдэгдэл, сайр мэтээр ерөнхийлөн дүрсэлнэ. Үүнээс ялгагдах том гол мөрний хуурай голдрилыг газар дээрх байршлын дагуу зурж, эргийг хаялбартай уялдуулна.

331. /F109_P/. Байр зүйн зурагт тэмдэглэгдэх даваа нь тухайн давааны хамгийн өндөр цэгтэй уялдах ёстой. Тэмдгийн дэргэд хүртвэрт - давааны өндрийг, хуваарьт- давааны ашиглагдах (давааг давж болох) хугацааг бичнэ.

332. /F110_L/. Хаялгатай эгц эрэгтэй усан тогтцыг байр зүйн зурагт дүрслэхдээ тодорхой масштабт дүрслэгдэхгүй хаялгатай газрыг салган үзүүлнэ. Мөн голын булан тохойг байр зүйн зургийн масштабт 1.5 мм-ээс их өргөнтэй бол дүрсэлнэ.

Байр зүйн зурагт эгц эргийн хамгийн их гүнийг 0.1 м-ээр үзүүлэх ба эрэг их урт бол хэд хэдэн газар үзүүлнэ. Хаялгагүй, мөн мөстөлттэй эгц эргийг ялгахын тулд тайлбарыг заавал хүрэн өнгөөр бичнэ.

333. /F111_L/. Голын булан тохойн 1.5 мм түүнээс бага өргөнтэйгөөр дүрслэх хаялгагүй эгц эргийг дор дурдсан байдлаар байр зүйн зурагт оруулна.

- оройн эргийг хавтгайд буулгах, дээд, доод эргийн шугам хоорондын зай 1 мм-ээс их байвал эгц эргийг хоёр зураасаар тэмдэглэнэ.

- хэрэв энэ зай 1 мм-ээс бага бол нэг зураасаар тэмдэглэх ба байр зүйн зурагт эргийн дээд ирмэг зохих байдлаар орсон байх ёстой.

Байр зүйн зурагт 1.5 мм-ээс их өргөнтэй дүрслэгдэх эргийг хаялгатай эрэг мэтээр үзүүлнэ.

334. /F112_L/. Хадтай эрэг, жалга нь тодорхой дүрслэгдэх хэмжээтэй, тусгаг нь тухайн масштабт 2 мм-ээс ихээр дүрслэгдэх бол зохих тогтсон Тэмдгээр үзүүлнэ. Хэрэв бага гүнтэй бол "хад" гэсэн тайлбар бичиглэл өгнө. Хадтай жалганы байр зүйн зураг дээрх дүрслэл нь агаараас авсан дүрстэй тохирох ёстой.

335. /F113_P/. Ганц нэгээр газраас огцом ил гарсан, богино хэмжээтэй цувраа хадыг үлдэц хад гэнэ. Үлдэц хадны Тэмдгийг газар оронд баримжаа болох үлдэц цохионд хэрэглэнэ. Тэдгээрийг Тэмдгээр дүрслэн "үлд.хад" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. 1 м-ээс өндөр үлдэц хадны өндрийг тодорхойлж байр зүйн зурагт оруулна.

336-337. /F114_P - F114_L/. Чулуун давс, шохойн чулуу, гөлтгөнө зэрэг чулуулаг, усны нөлөөлөлд идэгдэн шовгор болон ухагдаж хонхойсон, мөн мөнх хөлдүү чулуулгаас үүссэн дүрсийг шохойд идэгдэж тогтсон нүх гэнэ. Энэ нь хөндлөн огтлолоороо тухайн масштабт 2 мм-ээс багагүй дүрслэгдэж байвал Тэмдгээр дүрсэлнэ.

338. /F115_P/. Байгалийн үүсэлтэй хаялбараар илэрхийлэгдэхгүй довыг масштабын бус Тэмдгээр байр зүйн зурагт үзүүлнэ. Үргэлжилсэн хэлбэртэй бол /Тэмдэг F209_A, Тайлбар 363/ дов сондуултай гадаргын Тэмдгээр зурна.

339. /F116_P/. Агуйг байр зүйн зурагт оруулахдаа байршлаар нь оруулж "аг." гэсэн тайлбар бичиглэл өгнө. Хэрэв нэмэлт шаардлагаар агуйн газар доорх ерөнхий байдлыг зураглах бол тэдгээрийг хаялбараар зурж үзүүлнэ.

340. /F117_P/. Чиг баримжаа болох сондгой чулууг байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр үзүүлнэ.

341. /F118_L/. Нарийхан цувраа байрласан, орчин тойрондоо мэдэгдэхүйц өндөр, газрын хэвгийтэй уялдаагүй, овоолго чулуулгийг сэврэй хад гэнэ. Сэврэй хадыг тухайн масштабт илэрхийлэгдэхгүй тохиолдолд далан мэт хос шугамаар тэмдэглэнэ. Сэврэй хаданд харьцангуй өндөр бичнэ.

342. /F119_L/. Сөнөсөн галт уулын тогоо бэл орчмын нурмаар дүүрсэн царыг байр зүйн зурагт тэдгээрийн хэмжээ, чулуулгийн бүтцийг харгалзан битүү ба хагас битүү шороон болон хадан жалга мэт дүрсэлнэ. Бололцоотой нөхцөлд галт уулын царын ёроол ба ирмэгийн үнэмлэхүй өндрийг, жижиг тогооны харьцангуй гүнийг тодорхойлно.

343. /F120_L/. Шавар бүхий галт уулын тогооны Тэмдэгт "тог." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Ийм цар, гол төлөв далан хэлбэртэй байх учир тэдгээрийн өндрийг 0.1 м нарийвчлалтай тодорхойлж бичнэ.

344. /F121_L/. Уулын зам дагасан үелээ дэл чулууг байр зүйн зурагт үзүүлнэ.

345. /F122_L/. Байгалийн үүсэлтэй шороон хөмгийн Тэмдгийг далан хаялбараар илэрхийлэгдэхгүй тохиолдолд хэрэглэнэ. Ийм шороон хөмгийн өндрийн тодорхойлолтыг шаардлагатай тохиолдолд тухайлбал: хөрс сайжруулах ажлын сэдэвчилсэн зураг хийхэд өгнө.

346. /F123_L/. Хаялбараар илэрхийлэгдэхгүй тодорхой бус эрэг, түүний эргэлт тухайн масштабт 0.5 см ба түүнээс их бол мөргөцгийн Тэмдгээр тэмдэглэнэ. Эдгээр мөргөцгийн дүрслэл хаялбарын шугамтай огтлолцож болно.

347. /F124_L/. Хэвгийн дагуу нурсан сийрэг хөрснөөс үүссэн гадаргын хэлбэрийг гулгалт (нуранги) гэнэ. Байр зүйн зурагт үүнийг хүрэн тасархай шугамаар зурах ба хаялбарыг 3-3.5 мм урт, 1 мм зайтай, тасархай шугамаар үзүүлнэ.

348. /F125_L/. Усны хаялбарыг (гүний шатлалаар) газрын гадаргыг хаялбараар дүрслэхтэй адил байдлаар үзүүлнэ.

349-353. /F101_T, F106_T, F107_T, F110_T, F113_T/. Хаялбарын өндөр, өндрийн тоот, газрын гадарга дээрх элементийн нэр, үзүүлэлтүүд зэрэг нь эдгээр давхаргуудад зохих ёсоор бичигдэнэ.

8.21 Хөрс , газрын бичил гадарга

8.21.1 Хэрэв тухайн масштабын байр зүйн зурагт гадаргын бичил хэлбэр 1 см.кв-ээс их талбайд үзүүлэгдэх бол тэдгээрийг байр зүйн зурагт зааглан үзүүлнэ.

8.21.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

354-355. /F201_A – F201_P/. Тэгш, тэгш бус хэлбэртэй элсийг хаялбараар үзүүлж нэг төрлийн ерөнхий Тэмдгээр тэмдэглэнэ. Тэгш бус тогтоцтой элсийг үзүүлэхэд тайлбар бичиглэл хийж болно. Хэрэв элсний тэгш бус тогтоц хаялбараар илэрхийлэгдэж байвал тэдгээрийг төрлөөр ангилан "довцог элс", "бөөрөг элс" буюу "дов.элс" гэх мэт тайлбар бичиглэлийг өгнө. Хэрэв хаялбар элсний бичил хэлбэрийг илэрхийлж чадахгүй байвал "довцог 1-1.5 м өндөр", "бөөрөг 1.5-2 м гүн" гэх мэт тайлбар бичиглэл өгнө. Зургийн 1-1.5 дм.кв талбайд элсэрхэг гадаргын бичил хэлбэр, нэг төрлийн байгаа тохиолдолд бичиглэл хийнэ.

356. /F202_A/. Бутархай чулуу, хайргатай элсний гадаргыг байр зүйн зурагт үзүүлэхдээ урсгал ус, эрэгт давлагаагаар түрэгдсэн 0.1-10 см хөндлөн огтлолтой, хатуу чулуулаг, 0.1-1 см огтлолтой хайрга чулуутай хэсгийг үзүүлнэ. 10 см-ээс 1 м хэмжээтэй, уулын хөндийн тодорхой хязгаар нь мэдэгдэхгүй чулуутай гадаргыг тусгай Тэмдгээр үзүүлнэ.

357. /F203_A/. Шавар тойром /шал/ гэж шаварлаг талбайтай, хавтгай хэлбэрийн хотгор, хуурай газрыг хэлнэ. Зарим нэг богино хугацаанд ийм газар нь устай шавраар хучигдах ба бусад хугацаанд шавар тойром нь хуурай гадаргатай, олон хэлбэрийн өнцөг үүсгэсэн хагаралтай байна. Шавар тойрмын Тэмдгийг зурагт тэгш хуваарилан зурна. Хэрэв хязгаар нь тодорхой бол зааглан үзүүлнэ. 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт шавар тойром нь илэрхийлэгдэхгүй.

358. /F204_A/. Шаварлаг гадаргыг байр зүйн зурагт үзүүлэхэд шавар, шавранцар төрлийн ургамалгүй газрыг хамааруулна. Ийм гадаргад өргөн уудам газар нутгийг хамарсан тал хээрийн (хаялбараар илэрхийлэгдэх) говь газар хамаарагдах ба зарим газар нутагт тухайлбал өндөрлөг ба томоохон ганга жалгатай газар ч тохиолдоно.

359. /F205_A/. Хайрга, чулуу сайртай болон үйрмэг бутархай чулуутай гадарга нь өнцөг бүхий уулын чулуулгийн бөөгнөрлөөс бүрдэнэ. Сайр чулуутай гадарга нь тал газар тохиолдох ба түрэгдлээс үүсээгүй, хөндлөнгөөрөө 10 см хүртлэх хэмжээтэй, хурц өнцөг бүхий чулуутай гадарга байна. Үйрмэг бутархай чулуутай газар нь уулын тэгш орой, бэлд тохиолдох бөгөөд чулуу нь янз бүрийн хэлбэртэй байна. Хэрэв сайр чулуутай, үйрмэг бутархай чулуутай гадарга томоохон талбайтай, бусад гадаргатай нийлж байвал тэдгээрийг зааглан хязгаарлаж, "сайр чулуу" буюу "сайр чул.", "үйрмэг бутархай чулуу" буюу "үйр.бут.чул." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

360. /F206_L/. Чулуутай сайрын Тэмдгийг зэрэглэж ялгаагүй хаягдал, жижиг материалаас бүрдсэн, уулын бэлийг даган зурвас маягаар, уулын оройгоос түүний хөндийг уруудан тогтсон зурвасыг байр зүйн зурагт тэмдэглэхэд хэрэглэнэ.

361. /F207_A/. Ургаа чулуутай хатуу чулуулаг, бүхэл чулуун гадаргыг байр зүйн зурагт тухайн гадарга нүцгэн эсвэл салхины үйлчлэлээр хэдэн см царцдасаар хучигдсан тохиолдолд үзүүлнэ. Ийм гадаргын хаднаас ялгагдах онцлог нь огцом налуу багатай, хэсэг хэсгээр тогтоогүй байдаг. Тэдгээрийг хаялбартай давхцуулан зурж болохгүй. Хэрэв ийм гадаргын хязгаар сайтар мэдэгдэж байвал зааглана. Заримдаа бүхэл чулуун гадарга дээр цөөн тооны бут сөөг бусад ургамал ургасан байх тул Тэмдгийг хослуулан тэмдэглэж үзүүлнэ.

362. /F208_A/. Дов, довцогтой гадаргыг энэ Тэмдгээр үзүүлнэ. Харин дунджаар хөндлөнгөөрөө 5-10 м, өндрөөрөө 1-3 м хэмжээтэй дов довцог тухайн масштабт болон хаялбарын огтлолоор зурагт илэрхийлэгдэж чадахгүй. Дов, довцгийн орой нь бөмбөгөр эсвэл хавтгай байна. Дов, довцог бүхий гадаргыг тэмдэглэхдээ элсэн дов, довцог гэх мэт ижил төстэй, бичил хэлбэрийн гадаргыг

хамтатган үзүүлж болохгүй. Дов, довцогтой газар нь давс, намаг, ургамалтай бол Тэмдгийг хослуулан дүрсэлнэ.

363. /F209_A/. Дов сондуул бүхий гадаргын Тэмдгийг чийглэг шаарддаг тачир өвстэй ширэг, ургамлаар бүрхэгдсэн, бага хэмжээний довцогтой гадаргыг зурагт үзүүлэхэд хэрэглэнэ. Эдгээр гадаргыг ялгах хэмжүүр нь тухайн масштабын байр зүйн зурагт 1 см.кв-ээс их талбай бүхий зааг хязгаартай, бичил хэлбэрт гадаргын 0.3-0.7 м өндрөөр хэмжигдэнэ. Дов сондуултай гадарга нь тээврийн хэрэгслээр туулахад хүндрэлтэй бол 0.3-0.5 м өндөр эсвэл 0.5 м-ээс өндөр гэх мэт тайлбар бичиглэл өгнө.

8.22 Газрын гадарга дээрх байгууламж

8.22.1 Гол мөрөн эсвэл сувгийн усыг хааж усны түвшинг дээшлүүлэхэд зориулагдсан усан сан үүсгэх хаалтыг далан гэнэ. Хийц материалын хувьд төмөр, чулуун, модон, бетон, төмөр бетон, шороон гэх мэт ангилна. Байр зүйн зурагт даланг иж бүрэн байдлаар дүрслэн тайлбар бичиглэлийг өгнө.

8.22.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

364-366. /F301_A – F302_L/. Далан /овоолго шороо/ нь гол төлөв зам тээврийн байгууламж болох бөгөөд мөн өндөрлөгдсөн, гидротехникийн байгууламж юм. Эдгээр нь нам дор газрыг усанд автахаас хамгаалахад зориулагдсан учраас нэлээд өндөрлөгдсөн өргөн суурин байгууламж байх ба түүн дээгүүр бүрэн хөндлөн зүсэлт бүхий зам байгуулсан байж болно.

Тухайн масштабаас шалтгаалан даланг хоёр ба дан тасархай зураасаар үзүүлнэ. Энэ нь гол төлөв 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт хамаарагдана. Усны урсгал дагуу баригдаж буй шороон түрц, далан хаалтыг зурагт дараах нөхцөлд Тэмдгээр үзүүлнэ. Тухайлбал:

- далангийн урт байр зүйн зурагт 3 мм ба түүнээс их;

- далангийн өндөр бодит байдлаар 0.25 м-ээс их, зураг 0.5 м эсвэл 1 м үеийн өндөртэй;

- далангийн өндөр 1 м ба түүнээс өндөр, зураг 2 м ба 5 м үеийн өндөртэй;

Даланг хэлбэр хэмжээ, байрлалаар нь байр зүйн зурагт үзүүлэхээс гадна бэхэлгээтэй, бэхэлгээгүй, ямар материалаар хийгдсэнийг мэдээлэл болгож оруулна.

Байр зүйн зурагт 1 см урт илэрхийлэх далангийн хийцийг (материалыг) үзүүлнэ. Үүнийг "төм." - төмөр, "мод" гэх мэтээр үзүүлэх ба бичих зайгүй тохиолдолд "Т" - төмөр, "ТБ" - төмөр бетон, "М" - мод гэж тэмдэглэнэ.

Томоохон талбай эзлэх ташлуурын тэмдгийн зураасыг 1.5-2 буюу 3 дахин хэсэгчлэн зурж болно. Хэрэв ташлуурын дүрс нь өргөнөөрөө 3 см ба түүнээс их бол түүний дүрсийг тодотгохын тулд богино зураасыг урт зураасны 1/3-ийн урттай тэнцүү байхаар уртасгаж болно.

Ажлын даалгаварт заасан буюу тусгай зориулалтын сэдэвчилсэн зурагт овоолсон шороо ба ухсан газрыг түүний өндөр, гүний үзүүлэлтийн хамт (өндөр, гүн нь 0.5 м-ээс их, урт нь 0.3 м-ээс их) дүрсэлнэ. Урт хэмжээний далангийн харьцангуй өндрийг ойролцоогоор 7-10 см бүрт үзүүлнэ. 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт далангийн ус юүлэх хоолой, худгуудын оролт, гаралтын өндрийг, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт далангийн өргөнийг ажлын даалгаварт заасан /усжуулалтын зориулалттай сэдэвчилсэн/ тохиолдолд үзүүлнэ.

367-368. /F303_L – F304_L/. Ус зайлуулах зориулалтаар хийгдсэн суваг, шуудууг ямар нэг өөрчлөлтгүйгээр /налуу, эгц/ тухайн масштабын байр зүйн зурагт бодит байрлалаар нь оруулна. Зарим тохиолдолд, усжуулалтын зориулалттай

сэдэвчилсэн зурагт сувгийн өргөн, гүнийг үзүүлэхээс гадна эргийн болон ёроолын өндрийг тодорхойлох шаардлага гардаг. Суваг, шуудууны тодорхойлолтыг дор дурдсан байдлаар ангилж үзүүлнэ. Үүнд:

- 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт түүний үндсэн шаардлагаар объектууд дээр түүний өргөнийг үзүүлэх ба гүнийг 0.1 м нарийвчлалтай, 1:500, 1:1 000-ны масштабтай байр зүйн зурагт зөвхөн гүнийг үзүүлнэ.

- тодорхой шаардлагаар суваг, шуудууны ёроолын өргөнийг тодорхойлж тоон илэрхийллийг хуваарьт бичнэ.

Сувагт, шуудууны хуваарьт бичигдэх өргөний илэрхийллийг эргийн дээд зах хоорондын зай гэж үзнэ.

Баригдаж байгаа сувгийг байр зүйн зурагт ойлгомжтой болгохын тулд "барь." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

Газар доорх суваг бусад сүлжээг зөвхөн гидротехникийн зураг материалд үндэслэн байр зүйн зурагт оруулна. Гэхдээ зам дагуух ус зайлуулах зориулалттай хаалт бүхий эгц суваг үүнд хамаарах бөгөөд байр зүйн зурагт эдгээрийг тасалдалтай шугамаар үзүүлнэ.

369-370. /F305_P – F305_L/. Түүхийн холбогдолтой хиргисүүрийг байр зүйн зурагт тодорхой тохиолдолд "эрт." - эртний, "булш", "түүх." - түүхийн гэх мэт тайлбар бичиглэлтэй үзүүлнэ. Чулуун довыг дүрслэхэд "чул." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

371-372. /F306_L – F306_P/. Овоолсон хөрс, шороо, овоолгын Тэмдгээр үйлдвэрлэлийн ашигт малтмалын хураасан овоолго хаягдлыг тэмдэглэнэ. Уурхайн овоолго нь нэг буюу олон хэлхээтэй, хавтгай, конус хэлбэрийн, нуруулдсан гэх мэт байдаг. Овоолго дээр хаялбар татахад Тайлбар 304-307-г баримтлан үзүүлнэ.

Ухсан газар гэдэгт ил аргаар ашигт малтмал ашиглаж байсан (үйлдвэрийн зориулалтын бус) газар ухах техникээр газрын хөрсийг хуулсан гэх мэт газрыг хамааруулна. Хотгор гүдгэрийн нэгэн элемент болох нүхийг байр зүйн зурагт хоёр дүрслэлээр үзүүлнэ:

- байгалийн үүсэлтэй нь хүрэн, хүний гараар бүтсэн нь хар өнгөөр тус тус дүрслэгдэнэ. Ийм газарт "ухсан" гэсэн тайлбар хийнэ. Хэрэв хиймэл нүхийг аж ахуйн зориулалтаар ашигладаг бол, "тэж." - тэжээлийн, "өвс" - өвсний гэх мэт тайлбар бичиглэлийг өгнө. Шаардлагатай бол нүхний гүнийг 0.1 м нарийвчлалтай үзүүлнэ.

373. /F307_P/. Суварга, тахилгатай овооны төрлийн байгууламжийг 1:500, 1:1 000-ны масштабтай дэвсгэр зурагт тайлбар бичиглэлийн хамт (жишээ нь: "сувар." гэх мэт) дүрсэлнэ.

374-375. /F308_P – F308_A/. Оршуулгын газрыг том масштабын байр зүйн зурагт түүний доторх байгууламж, зам, ургамлын хамт дүрсэлнэ.

Оршуулгын газар дотор байгаа барилга, байгууламж, бусад объектыг байр зүйн зурагт холбогдох Тэмдгүүдээр дүрсэлнэ. Оршуулга доторх мод - бутлаг ургамлыг бодит байрлалаар нь шигүү модтой, сийрэг модтой, сондгой модтой, зулзаган, шигүү буюу хэсэг буттай гэх мэт төрөлжүүлэн дүрсэлнэ. Боломжтой бол ургамлын бүрхэвчийг нугын, хээрийн гэж ангилж үзүүлнэ.

Оршуулгын газар нь 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр дүрслэгдэх бол "орш.газ." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

376. /F309_P/. Эртний барилга байгууламж, сүм хийдийн туурийг уг Тэмдгээр дүрслэн "туурь" гэсэн тайлбар бичиглэл хийнэ.

377. /F310_L/. Түүхийн холбогдолтой ханыг (Эрдэнэ зуугийн хана гэх мэт) байр зүйн зурагт ялангуяа 1:2 000-ны масштабтай байр зүйн зурагт гадна талын үндсэн сууриар нь үзүүлнэ. Түүхийн холбогдолтой ханыг зурагласан бол "түүх." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

378-379. /F301_T, F307_T/. Далан, сувгийн үзүүлэлт, газрын гадарга дээрх байгууламжийн тайлбар бичиглэл эдгээр давхаргад бичигдэнэ. Жич: *шороо, хирг., овоо, овоол.*

8.23 Ургамал зүй

8.23.1 Ургамлыг байр зүйн зурагт дүрслэхэд: модлог-өндөр голчтой ердийн ой, нам ургасан жижиг ой, суулгасан өндөр голчтой ой, ойн залуу суулгац, мод үржүүлгийн ой, ой хамгаалах зурвасын модлог суулгац, шатсан ба хөрөөдөж огтолсон ой, сондгой мод, бутлаг-бутлаг ба хагас бутлаг бут сөөг; өвслөг-тодорхой үндэсгүй үргэлжлэн ургасан, хөвд хаг, өвслөг ургамал, мөөг болон усны ургамлууд гэх мэт ангилна. Ойн Тэмдгийг тогтмол үржүүлдэггүй, зэрлэг /байгалийн/ модлог ойг дүрслэхэд хэрэглэнэ.

8.23.2 Төрөл бүрийн ургамалтай газрын зааг нь тодорхой бус бол (мөн хөрс нь) шилжилтийн заагийг үзүүлэхэд ургамлын Тэмдгийг хольж тэмдэглэнэ.

8.23.3 Ургамлын бодит хязгаарыг хэрэв талбай нь 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт 1 см.кв-ээс их бол, бусад масштабт 0.5 см.кв-ээс их бол үзүүлнэ.

8.23.4 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

380. /D101_A/. Байр зүйн зурагт ойг дүрслэхэд ногоон өнгө өгнө. Бүдүүн суулгац ой, өргөн зурвасын суулгац ой, нэгэн төрлийн болон холимог жимсний мод, техникийн зориулалттай модлог ургамлын тариалан зэргийг ногооноор будаж Тэмдэг дүрслэлээр үзүүлнэ. Зулзаган мод, залуу суулгац, хэвтээ ургамал, хулс, заг, өргөст болон бусад бут сөөг, жимс, техникийн болон бутлаг тариалан, зүлэг, цэцгийн мандал зэргийг графикаар дүрсэлнэ.

381. /D102_L/. Ургамлыг тархац, хил хязгаарыг зааглан үзүүлэхэд уг цэгэн хүрээн Тэмдгийг ашиглана.

382-383. /D103_P – D104_P/. Ойн зонхилох модыг тэдгээрийн бүтэц, өндрийг м-ээр тэмдэглэн зурагт үзүүлнэ. Бүтцийг навчит, шилмүүст гэж ангилна. Холимог ойг аль давамгайлах модны бүтцийг харгалзан үзүүлнэ. Энэ тохиолдолд тэдгээрийн Тэмдгийн зүүн талд товчлоогүй тайлбар бичиглэл өгнө. Хэрэв ойн бүтцийн 80% ба түүнээс их хувь нь нэг төрлийн бол нэг нэр, бусад тохиолдолд хоёр нэр бичнэ. Гол нэрийг дээд талд, хоёр дахь нэрийг доод талд нь бичнэ. Модны өндрийг (м-ээр) орой хүртэл, голчын хэмжээг хүний цээжний түвшинд авсан хэмжээгээр үзүүлэх ба мөн мод хоорондын зайг үзүүлнэ. Хэрэв үзүүлэлтийг бичих зай бага бол модны өндрийг бичиж болно. Ойн бүтэц, үзүүлэлтийг бичих талбай хангалттай тохиолдолд 1-2 үзүүлэлтийг 1 дм.кв талбайд суулгацын өөрчлөлтийг харгалзана бичнэ.

384. /D105_A/. Бүдүүн голчтой таримал бус модтой ойг 4 м түүнээс дээш өндөртэй үргэлжилсэн ой, 6 м түүнээс дээш өндөртэй намхан ургамалтай, холимог ургасан, 20% түүнээс илүү шигүүжилтэй хэлбэрээр ойг зурагт дүрслэн үзүүлнэ. Гэхдээ суулгацын онцлог, хэрэглээний гол чиглэлийн дагуу ойг хэсэглэн зааглана. Хот доторх суулгац ойг цэцэрлэг байдлаар (Тайлбар 544) тэмдэглэнэ. Өтгөн зулзаган ойг дүрслэхэд нэмэлт шаардлагаар "*өтг.зулз.ой*" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

385. /D106_A/. Намхан зулзаган модтой ойгоор 4 м-ээс ихгүй өндөртэй, өргөжин тэлж ургах боломжгүй (намаг, чулуун хөрс гэх мэт) газарт ургасан, нас гүйцсэн модыг зурна. Гоёл чимэглэлийн зориулалттай таримал тачир суулгац 1-1.5 м өндөртэй байна.

386. /D107_A/. Муруй, далиу мод ургасан ойг өндөр голчтой, тэгш бус мөчиртэй ойтой адил Тэмдгээр дүрсэлнэ. Хөрсний гулгалт, нуралт бүхий газар ургасан муруй, далиу модтой ой уулархаг бүст тохиолдоно.

387. /D108_A/. Ширэнгэ ой, бут сөөгийг 4 м-ээс бага өндөртэй, залуу ойгоор тэмдэглэнэ. Хэрэв дундаж өндөр нь 1 м хүрэхгүй бол м-ийн 1/10-ээр тодорхойлж бичнэ. Бут сөөгийн бүдүүнийг зөвхөн газар усжуулалтын зориулалттай сэдэвчилсэн зурагт бичиж өгнө.

388. /D109_L/. Ойн зурвасыг масштабаас хамааруулан 5 мм ба түүнээс өргөн, 1-5.0; 0.5-1 ба 0.5 мм-ээс нарийн гэж ангилна.

Хэрэв зурвасын хэсэг нэг талаасаа буюу хоёр талаасаа сувгаар (устай, усгүй), хашаа, хаалтаар тусгаарлагдсан бол, тэдгээрийн аль нэгийг үзүүлнэ. Хэрэв зурвас дагуу зам, ган хоолой, утсан шугам тавигдсан бол зурвас хангалттай өргөнтэй нөхцөлд бүгдийг үзүүлнэ. Улсын, засаг захиргааны хил зурвастай давхцаж байвал зурвасын голоор (тэнхлэгээр), нарийн зурвас бол зурвасны хоёр захаар хилийг үзүүлнэ.

389. /D110_A/. Бүдүүн голчтой, сийрэг ойн Тэмдгийг 20%-иас бага шигүүжилтэй, мөчир хоорондын зай нь ойн дунд хэсэгт мөчрийн диаметрийн 2-5, хуурайшил ихтэй нутагт мөн мөчрийн диаметрийн 7-той тэнцэх зайтай нөхцөлд хэрэглэнэ. Сийрэг ойн шигүү, сийрэг байдлыг газар дээр нь тогтоох шаардлагатай.

390. /D111_A/. Зулзаган мод зонхилдог сийрэг ой болон зулзаган ойг байр зүйн зурагт үзүүлэхэд / D106_A, D108_A/ тайлбарыг баримтална.

391. /D112_A/. Салхи, усан давалгаанд нэрвэгдсэн модны овоолго, дархи модыг ойн адил үзүүлнэ. Үүнд тухайн ойн талаас их, талаас бага нэрвэгдсэн байдлыг харгалзана. Хэрэв талаас их нь нэрвэгдсэн бол Тэмдгийг талбайд жигд зурж үзүүлнэ. Талаас бага нь нэрвэгдсэн бол нэрвэгдэлгүй үлдсэн модыг оруулж өгнө. Хэрэв ойн гүнд салхи, усан давалгаанд хэсэг газар нэрвэгдсэн бол түүнийг тодорхой ялгарах хязгаараар нь зааглана. Сийрэг ойд салхи, усан давалгаанд нэрвэгдсэн газрыг тусгайлан үзүүлэхгүй.

392. /D113_A/. Шатсан, хатсан, хуурайшсан ойн хэсгийг нэг Тэмдгээр үзүүлнэ. Шаардлагатай нөхцөлд хатсан ойд "хат." эсвэл "хуур." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Түймэрт нэрвэгдсэн ойн хэсэг мөчиртэй үлдэх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд тухайн талбайд бүдүүн голчтой болон шатсан ойн Тэмдгийг хослуулан хэрэглэнэ. Ойн гэмтсэн (шатсан гэх мэт) талбайд ургасан бут сөөг, бусад ургамлыг байр зүйн зурагт бодит талбайн хэмжээгээр оруулна.

393. /D114_A/. Огтолсон ойн хэсгийг байр зүйн зурагт оруулахдаа ойн хожуул бүхий талбайг оруулна. Байгалийн болон хөдөө аж ахуйн сэдэвчилсэн зурагт ямар ургамал болох хожуул бүрийг бодит байрлалаар нь оруулна.

394. /D115_P/. Сондгой ургасан (ганц мод) модыг 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зурагт чиг баримжаа болох, түүх соёлын гэсэн хоёр утгаар навчит, шилмүүст, жимсгэнийн болон бусад гэж хуваан Тэмдгээр үзүүлнэ.

1:500, 1:1 000-ны масштабтай сэдэвчилсэн зурагт сондгой модыг зураглахдаа хэд хэдэн Тэмдгийг хэрэглэж жимсгэнийн модны Тэмдгийн хажууд "алим", "жүрж" гэх мэт нэрийг бичнэ.

395 /D116_P/. Байр зүйн зурагт өвслөг ургамлыг нугын, өндөр өвслөг, чийгийн, талын, зэгсний гэж ангилан үзүүлнэ. Эдгээрээс өндөр өвслөг нь 1 м-ээс 3.5 м өндөртэйгөөр ялгагдах ба зэгсний төрлийн ургамал үүнээс өндөр эсвэл нам байх бөгөөд бусад нь 1 м хүрэхгүй өндөртэй байдаг. Эдгээр төрлийг ургамал тус бүрийн Тэмдгээр дүрсэлнэ. Өвслөг ургамлыг эзэлж буй талбайгаар нь эсвэл байрласан зурвасын тэнхлэгээр зурж үзүүлнэ.

396-397. /D117_A - D118_A/. Байр зүйн зурагт бут, сөөг, загийг хэсэгчлэн болон нэлэнхийд нь Тэмдгээр үзүүлнэ. Бут, сөөг нь газраас шууд мөчирлөсөн байдлаараа болон өндрөөрөө, нас гүйцсэн модноос ялгарна. Байр зүйн зурагт тэдгээрийг бөөн бут, сөөг, өргөст бут, сөөг, зурвас бут, сөөг гэж ангилна. Шаардлагатай тохиолдолд бут сөөг, загийг тэдгээрийн бөөгнөрөл, чиглэлийг харгалзан хосолсон Тэмдгээр дүрсэлнэ.

Тусгай зориулалтын сэдэвчилсэн зурагт бут, сөөг, загийн хүрээнд тэдгээрийн төрөл, дундаж өндрийг бичнэ. 1 м хүртэлх өндөртэй шугуйг 1/10 м-ийн, түүнээс өндрийг 1/2 м-ийн нарийвчлалтай тодорхойлно.

398-399. /D119_A - D120_A/. Хэсэг хэсгээр ургасан, үргэлжлэн ургасан өргөст бут сөөг, ширэнгийг тус бүр ялган Тэмдгээр тэмдэглэнэ. Ийм бут сөөг, ширэнгийг хүрээлэн зурж тодорхойлолтыг өгнө.

400-401. /D121_A – D122_A/. Хагас бутлаг, сөөг, тачир бяцхан бут дунджаар 0.5 м өндөр, бут хэлбэртэй дээд хэсэг нь өвлийн улиралд мөхдөг. Сийрэг болон шигүү хэсэгчлэн ургасан эсвэл үргэлжлэн хүрээлэгдсэн, ургамлын бүрхэвч нь говь цөлийн хагас бутлаг эсвэл ой, намаг бүхий газрын тачир бутнаас бүрдэнэ. Хагас бутлаг ургамалд: шарилжийн төрлийн ургамал хамаарна.

402. /D123_A/. Нугын өвслөг ургамлыг ойн цоорхойн, талын, нуур-гол, мөрний эрэг орчмын гэх зэргээр ангилж байр зүйн зурагт үзүүлнэ.

403. /D124_A/. Сахлаг өвслөг ургамал гол төлөв асар том залаатай, шүхэр хэлбэрийн ургамал байдаг. Задгай газар чиглэл болохуйц ургасан ийм ургамлыг Тэмдгийн үндсэн суурь өнгөн дээр онцгойлон тэмдэглэж үзүүлнэ.

404. /D125_A/. Чийг шаарддаг чийгтэй газрын өвслөг ургамалд өлөн өвс, цахилдаг зэрэг багтдаг. Эдгээрийг зураглах үед хэдийгээр зохих чийг аваагүй байсан ч тухайлсан Тэмдгийг хэрэглэнэ. Мөн эдгээр ургамлыг намгийн хүрээнд Тэмдгийг нь жигд хуваарилахгүйгээр зурна.

405. /D126_A/. Зэгсний төрлийн ургамлыг газар дээр эсвэл усанд байгаа байрлалаар нь үзүүлнэ. Усны эргээр ургасныг хүрээлэх ба усанд байгааг хүрээлэн зааглахгүй, хамгийн захын ургамал нь хязгаар нь болж өгнө.

406. /D127_A/. Тал хээрийн өвслөг ургамал нь олон жилийн ган гачигт тэсвэртэй хялгана төрлийн ургамал байна. Хэрэв эдгээр нь том талбайг эзлэн хүрээлэгдэн зааглагдсан бол Тэмдэг бүхий талбайгаар зурна.

407. /D128_A/. Заг нь модлог, бутлаг хэлбэртэй мушгирсан голтой, навч муутай, говь цөлийн ургамал юм. Заг гол төлөв элсэнд ургах ба хэсэг хэсгээр эсвэл үргэлжилсэн заримдаа тасарч ургасан байдалтай ургадаг. Хар заг нь 6 м хүртэл өндөртэй модлог ургамал бөгөөд элсэрхэг, давсархаг, шаварлаг хөрсөнд ургадаг. Цагаан заг нь 3.5 хүртэл өндөртэй, бутлаг шинжээр ялгагдах бөгөөд түүнийг элсний нүүлтээс хамгаалахад ашигладаг.

408-409. /D129_A – D130_A/. Хөвд ба хагдны төрлийн өвсийг өндөр өвслөг ба бутлаг ургамалгүй талбайд ургасан байдлаар нь зурагт үзүүлнэ. Хөвдлөг ургамлын Тэмдэг нь төрөл бүрийн хөвдлөг ургамлын бүрхэвчийг үзүүлэхэд зориулагдана.

410. /D131_A/. Хэвтээ ургадаг модлог ургамал, бут сөөгийн Тэмдэг нь байгалийн таатай бус нөхцөлд уулын оройн хэсэгт 0.5-3 м өндөр ургасан, навчит ба шилмүүст төрлийн модыг дүрслэхэд зориулагдана.

